

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20.. оны ... дугаар  
сарын ... -ны өдөр

Улаанбаатар  
хот

### АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

#### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилго

1.1.Энэ хуулийн зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт ашигт малтмалыг эрэх, хайх, ашиглах, баяжуулах харилцааг зохицуулах, геологи, уул уурхайн салбарын тогтолцоог бэхжүүлэх, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

#### 2 дугаар зүйл.Ашигт малтмалын хууль тогтоомж

2.1.Ашигт малтмалын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

#### 3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хуулиар ус болон газрын тосноос бусад ашигт малтмал, түүнтэй холбоотой үүсэх харилцааг зохицуулна.

3.2.Газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг тэгш шударга хүртээхтэй холбоотой харилцааг тусгай хуулиар зохицуулна.

3.3.Хөгжлийн төсөл, хөтөлбөрийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг ашиглахтай холбогдсон харилцааг Засгийн газрын баталсан журмаар зохицуулна.

#### 4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“эрдэс баялаг” гэж геологийн зураглал болон сэдэвчилсэн судалгаа, эрэл, хайгуулын ажлаар илрүүлж тоо хэмжээ нь үнэлэгдсэн, эдийн засгийн ач холбогдол нь нарийвчлан үнэлэгдээгүй эрдсийн хуримтлалын хэсгийг;

4.1.2.“ашигт малтмал” гэж геологийн хувьсал, өөрчлөлтийн дүнд газрын гадаргуу, түүний хэвлийд болон ашиглалт, баяжуулалтын үйл ажиллагаанаас бий болсон, эдийн засгийн хувьд ашигтай эрдсийн хуримтлалын хэсгийг;

4.1.3. “геологийн судалгаа” гэж геологийн тогтоц, ашигт малтмалын тархалт, байршлын зүйн тогтлыг судлах, ашигт малтмалын хэтийн төлөвийг тогтоох, ордыг илрүүлж үнэлгээ өгөх, уул-техникийн болон шаардлагатай бусад нөхцөлийг тодорхойлох зорилгоор шинжлэх ухааны үндэслэл бүхий арга аргачлалын дагуу гүйцэтгэх тодорхой үе шаттай цогц үйл ажиллагааг;

4.1.4. “эрлийн үйл ажиллагаа” гэж эрдсийн хуримтлал бүхий талбайг ялгах, түүний хэтийн төлөв, эдийн засгийн ач холбогдлыг урьдчилан үнэлэх, цаашид хайгуулын ажил хийх эсэхийг тодорхойлох зорилго бүхий газрын хэвлийн иж бүрэн судалгааны ажлыг;

4.1.5. “хайгуулын үйл ажиллагаа” гэж газрын гадаргуу, түүний хэвлийд геологи, хайгуулын арга аргачлалын дагуу судалгаа хийн, эрдсийн хуримтлалын байршил, хэлбэр, хэмжээ, агуулга, эрдсийн бүрэлдэхүүн, түүний баялаг, ашигт малтмалын нөөцийн хэмжээг нарийвчлан тогтоож геологи-эдийн засгийн үнэлгээ өгөхийг;

4.1.6. “ашигт малтмалын орд” гэж геологийн хувьсал, өөрчлөлтийн дүнд газрын гадарга, түүний хэвлийд бүрэлдэн тогтож чанар, нөөц нь тодорхойлогдсон, үйлдвэрийн аргаар олборлоход эдийн засгийн хувьд ашигтай эрдсийн хуримтлалыг;

4.1.7. “ашигт малтмалын ордын нөөц” гэж хайгуулын ажлын үр дүнд ашигт малтмалын биетийн хэлбэр, хэмжээ, агуулга, эрдсийн бүрэлдэхүүн, чанар нь тогтоогдож нөөцийг нь тооцоолсон, эдийн засгийн ач холбогдолтой эрдэс баялгийн хэсгийг;

4.1.8. “ашиглалтын үйл ажиллагаа” гэж ашиглалтын тусгай зөвшөөрлөөр олгогдсон эрхийн хүрээнд газрын гадаргуу, түүний хэвлийгээс ашигт малтмал олборлох, баяжуулах, борлуулах болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагааг;

4.1.9. “ашиглалтын үеийн хайгуул” гэж уурхайн тогтвортой үйл ажиллагааг хангах зорилгоор ашигт малтмалын хүдрийн биет, үе, давхаргын хэмжээнд хайгуулын ажлыг гүйцэтгэн нөөцийн тоо хэмжээг баталгаажуулах түүний зэрэглэлийг нарийвчлан тогтоохыг;

4.1.10. “баяжуулалтын үйл ажиллагаа” гэж ашигт малтмалын нэгжид ногдох ашигт агуулгыг технологийн дагуу нэмэгдүүлж баяжмал, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагааг;

4.1.11. “хайгуулын тусгай зөвшөөрөл” гэж энэ хуулийн дагуу хайгуулын үйл ажиллагаа явуулах эрх олгосон баримт бичгийг;

4.1.12. “ашиглалтын тусгай зөвшөөрөл” гэж энэ хуулийн дагуу ашиглалтын үйл ажиллагаа явуулах эрх олгосон баримт бичгийг;

4.1.13. “баяжуулалтын тусгай зөвшөөрөл” гэж энэ хуулийн дагуу баяжуулалтын үйл ажиллагаа явуулах эрх олгосон баримт бичгийг;

4.1.14. “тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэж энэ хуулийн дагуу ашигт малтмалын хайгуул, ашиглалт, баяжуулалтын үйл ажиллагаа явуулах эрх авсан, эсхүл түүнийг энэ хуульд заасан нөхцөл, журмын дагуу эрх шилжүүлэн авсан хуулийн этгээдийг;

4.1.15. “үүсмэл орд” гэж олборлолт, боловсруулалт, баяжуулалтын явцад ялгагдсан ашигт малтмалын тодорхой агуулга бүхий дахин боловсруулахад эдийн засгийн үр ашиг гаргаж болохуйц хүдэр, ашигт малтмалын овоолгыг;

4.1.16. “нэгж талбар” гэж урьдчилан тодорхойлсон уртраг, өргөргийн дагуу тогтмол 10 секундйн хэмжээтэй 4 өнцөгт талбайг;

4.1.17. “хаалтын үйл ажиллагаа” гэж ашиглалтын үйл ажиллагааны явцын нөхөн сэргээлт, уурхайн олборлолт, баяжуулах үйлдвэрийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг зогсоосноос хойш тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбай болон үйлдвэрийн талбай дахь уурхай, овоолго, далан, бусад байгууламжийн физик, химийн тогтвортой байдлыг хангах, нөхөн сэргээлт хийх, орчны аюулгүй байдлыг хангах, хаалтын дараах хяналт шинжилгээ, арчилгаа, тордолтыг гүйцэтгэхэд чиглэсэн цогц арга хэмжээг;

4.1.18. “хаалтын санхүүжилтийн баталгаа” гэж тухайн уурхай, баяжуулах үйлдвэрийн хаалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулах санхүүгийн хэрэгслийг;

4.1.19. “үндсэн ашигт малтмал” гэж ашигт малтмалаас технологийн хувьд нэн түрүүнд эдийн засгийн ашигтайгаар ялгаж авах бололцоотой эрдэс, химийн элементийг;

4.1.20. “дагалдах ашигт малтмал” гэж химийн нэгдлийн хувьд үндсэн ашигт малтмалыг салшгүй дагалдаж байдаг, технологийн хувьд ялган авах боломжтой бөгөөд эдийн засгийн хувьд ашигтай химийн элементийг;

4.1.21. “түгээмэл тархацтай ашигт малтмал” гэж үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж болох элбэг тархалт бүхий нуурын давс, хужир, шүү, элс, хайрга, дайрга, тоосгоны шавар, боржин, гантиг, хүрмэн чулууны хуримтлалыг;

4.1.22. “хайгуулын ажлын үр дүнгийн тайлан-техник, эдийн засгийн үндэслэл” гэж геологийн мэдээлэл, хайгуулын үр дүн, нөөцийн тооцоолол, орд ашиглахтай холбоотой хүчин зүйлсийг иж бүрэн тооцсон баримт бичгийг;

4.1.23. “техникийн зураг төсөл” гэж уурхай, үйлдвэрийн байршил, барилга байгууламж, тоног төхөөрөмж, дэд бүтцийн төлөвлөлт, үйл ажиллагааг иж бүрэн, нарийвчлан тооцсон техникийн баримт бичгийг.

4.1.24. “зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл” гэж хайгуулын ажлын үр дүнгийн тайлан-техник, эдийн засгийн үндэслэл, техникийн зураг төсөл, хаалтын төлөвлөгөө боловсруулагч этгээдэд олгох эрхийг;

4.1.25. “уурхайн эдэлбэр” гэж газрын хэвлийд орших геологийн тогтцын олборлох хэсгийг газрын гадаргад давхцуулсан талбайг;

4.1.26. “гүйцээх хайгуул” гэж хайгуулын ажлын үед баялгаар үнэлэгдсэн ашигт малтмалын хүдрийн биет, давхаргын геологийн тогтоц, хэлбэр, хэмжээ, технологийн шинж чанар, уул техникийн нөхцөл болон бусад нөхцөлийг ордын нөөцийн ангиллын шаардлагын түвшинд нарийвчлан судлах үйл ажиллагааг;

4.1.27.“хайгуулын ажлын зардлын доод хэмжээ” гэж хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд гүйцэтгэх хайгуулын ажилд тухайн жилд зарцуулсан байвал зохих энэ хуулиар тогтоосон зардлын доод хэмжээг;

4.1.28.“стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд” гэж үндэсний аюулгүй байдал, улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх хэмжээний, эсхүл жилд Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний таван хувиас дээш хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа буюу үйлдвэрлэх боломжтой ордыг.

## **5 дугаар зүйл.Ашигт малтмал эрэх, хайх, ашиглах, баяжуулах үйл ажиллагааны зарчим**

5.1.Ашигт малтмалыг эрэх, хайх, ашиглах, баяжуулах үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

5.1.1.ашигт малтмалыг хайх, ашиглах, баяжуулах үйл ажиллагааг зөвхөн тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх;

5.1.2.ашигт малтмалыг эрэх, хайх, ашиглах, баяжуулах, борлуулах бүх үе шат нь төрийн хяналтад байх;

5.1.3.талуудын оролцоо тэгш, шударга, ил тод, харилцан үр ашигтай байх ба хүртэх үр шимийн хэмжээгээр хариуцлага хүлээх;

5.1.4.тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайд эрэл, хайгуулын үйл ажиллагаанаас уурхай, үйлдвэрийг хаах хүртэл бүх үе шатанд ашиглах боломжтой эрдсийн хуримтлал бүрийг илрүүлж, тогтоогдсон ашигт малтмал тус бүрийн нөөцийг цогцоор нь ашиглах;

5.1.5.тусгай зөвшөөрөл олгогдсоноос эхлэн уурхай, үйлдвэрийг хаах хүртэлх хугацаанд хүн ам, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бага түвшинд байлгах техник, технологи, дэд бүтэц, тээвэрлэлтийн хувьд оновчтой шийдэлтэй үйлдвэрлэл явуулах;

## **6 дугаар зүйл.Ашигт малтмалын өмчлөл**

6.1.Монгол Улсын газрын гадаргуу болон түүний хэвлийд байгалийн байдлаараа оршиж байгаа ашигт малтмал төрийн нийтийн өмч байна.

6.2.Энэ хуулийн 6.1-д заасан төрийн нийтийн өмчийг хайх, ашиглах эрхийг зөвхөн энэ хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангасан хуулийн этгээдэд хугацаатайгаар олгоно.

6.3.Улсын төсвийн хөрөнгөөр эрэл, хайгуул хийж нөөцийг нь тогтоосон ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг тухайн ордыг ашиглах гэрээгээр тодорхойлно. Уг гэрээгээр тогтоосон төрийн эзэмшлийн хувь, хэмжээг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулж болно.

6.4.Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг хувийн өмчит хуулийн этгээдтэй хамтран ашиглавал төрийн оролцооны хэмжээ 50 хүртэл хувьтай байж болох бөгөөд

уг хэмжээг төрөөс оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан орд ашиглах гэрээгээр тодорхойлно. Уг гэрээгээр тогтоосон төрийн эзэмшлийн хувь, хэмжээг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулж болно.

6.5.Улсын төсвийн оролцоогүйгээр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг эзэмшигчийн тухайн ордод оруулсан хөрөнгийн 34 хүртэлх хувьтай тэнцэх хувьцааг төр эзэмшиж болох бөгөөд уг хэмжээг төрөөс оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан орд ашиглах гэрээгээр тодорхойлно. Уг гэрээгээр тогтоосон төрийн эзэмшлийн хувь, хэмжээг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулж болно.

6.6.Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа этгээд нь хувьцааныхаа 10-аас доошгүй хувийг Монголын хөрөнгийн биржээр арилжина.

## **7 дугаар зүйл.Тусгай зөвшөөрлийн төрөл**

7.1.Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл нь дараах төрөлтэй байна:

- 7.1.1.ашигт малтмал хайх;
- 7.1.2.ашигт малтмал ашиглах;
- 7.1.3.ашигт малтмал баяжуулах.

7.2.Байгалийн өнгөт чулууг ашиг олох зорилгоор хайх, ашиглах үйл ажиллагааг энэ хуулийн 7.1-д заасны дагуу тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ.

7.3.Нутгийн захиргааны байгууллагын зөвшөөрсөн талбайгаас иргэд түгээмэл тархацтай ашигт малтмалыг ашиг олох зорилгогүй, худалдан борлуулахгүйгээр өөрийн ахуйн хэрэгцээнд тусгай зөвшөөрөлгүйгээр ашиглаж болно.

7.4.Энэ хуулийн 7.3-т зааснаас бусад тохиолдолд ашигт малтмалын хайгуул, ашиглалт, баяжуулалтын үйл ажиллагааг зөвхөн тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ.

7.5.Нэг тусгай зөвшөөрлийг зөвхөн нэг хуулийн этгээдэд олгоно.

7.6.Энэ хуулийн дагуу олгогдсон тусгай зөвшөөрлийн талбайд ашигт малтмалыг хайх, ашиглах, баяжуулах тусгай зөвшөөрөл давхардуулж олгохгүй.

## **8 дугаар зүйл.Ашигт малтмал хайх, ашиглах, баяжуулахыг хориглосон, хязгаарласан газар**

8.1.Ашигт малтмалыг хайх, ашиглах, баяжуулах үйл ажиллагааг дараах газарт явуулахыг хориглоно:

- 8.1.1.улсын тусгай хамгаалалттай газар;
- 8.1.2.улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар;

8.1.3.байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай;

8.1.4.цөмийн төхөөрөмж барих, ашиглах зориулалтаар олгосон газар;

8.1.5.аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих газар;

8.1.6.гол, мөрний урсац бүрэлдэх эх.

8.2.Энэ хуулийн 8.1.6-д заасан хориглосон газрын хилийн заагийг Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

8.3.Ашигт малтмал хайх, ашиглах, баяжуулах үйл ажиллагаа явуулахыг хориглосон газрыг энэ хуулиар тогтооно.

8.4.Ашигт малтмалыг хайх, ашиглах, баяжуулах үйл ажиллагааг дараах газарт хязгаартай явуулж болно:

8.4.1.зам, шугам сүлжээний газар;

8.4.2.ойн сан бүхий газар;

8.4.3.улсын хилийн зурвас газар;

8.4.4.усны сан бүхий газрын хамгаалалтын бүс.

8.5.Энэ хуулийн 8.4-т заасан хязгаарласан газрын мэдээлэл, шийдвэрийг холбогдох байгууллага нь ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тухай бүр хүргүүлж, мэдээллийн санд бүртгүүлнэ.

8.6.Энэ хуулийн 8.4-т заасан газарт хайх, ашиглах, баяжуулах үйл ажиллагаа явуулахдаа холбогдох хуулиар зөвшөөрсөн хэм хэмжээг мөрдөж ажиллана.

## **9 дүгээр зүйл.Тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавигдах ерөнхий шаардлага**

9.1.Тусгай зөвшөөрлийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, татвар төлөгч хуулийн этгээдэд энэ хуульд заасан журмын дагуу олгоно.

9.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байх хугацаанд энэ хуулийн 9.1-д заасан шаардлагыг хангаж ажиллана.

9.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч болон түүний туслан гүйцэтгэгч нь Монгол Улсын иргэдийг ажлын байраар хангах үүрэг хүлээх ба тухайн хуулийн этгээдийн ажиллах хүчний бүрэлдэхүүнд дараах шаардлага тавигдана:

9.3.1.гадаад ажилтны тоо нийт ажилтны 10 хувиас хэтрэхгүй байх;

9.3.2.Монгол ажилтнуудын 5-аас доошгүй хувь нь уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа тухайн сум, дүүргийн иргэд байх.

9.4.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 9.3.1-д зааснаас илүү хэмжээгээр гадаадын иргэдийг авч ажиллуулсан ажлын байр тутамд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх, 9.3.2-т зааснаас бага хэмжээгээр орон нутгийн иргэдийг авч ажиллуулсан ажлын байр тутамд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төлбөрийг сар бүр төлнө.

9.5.Энэ хуулийн 9.4-т заасан төлбөрийг тухайн сум, дүүргийн төсөвт төвлөрүүлж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр шинээр бий болгох, соёл, боловсролын болон эрүүл мэндийн салбарт зарцуулах бөгөөд энэ талаархи журмыг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

## **10 дугаар зүйл.Геологи, уул уурхайн салбарын багц дүрэм**

10.1.Геологи, уул уурхайн салбарын багц дүрэм нь дор дурдсан дүрэм, журам, заавраас бүрдэнэ:

10.1.1.геологийн судалгаа, эрлийн ажлыг төлөвлөх, санхүүжүүлэх, гүйцэтгэх, хянах, үр дүнг хүлээн авах журам;

10.1.2.ашигт малтмал хайгуулын үйл ажиллагааны журам;

10.1.3.ашигт малтмал ашиглалт, баяжуулалтын үйл ажиллагааны журам;

10.1.4.уурхай, баяжуулах үйлдвэрийн хаалтын үйл ажиллагааны журам, хаалтын төлөвлөгөөг боловсруулах, хаалтын үйл ажиллагааны санхүүжилтийг тооцох аргачлал;

10.1.5.геологи, эрдэс баялгийн мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны журам;

10.1.6.салбарын мэргэшсэн мэргэжилтэнд эрх олгох, сунгах, цуцлах журам;

10.1.7.ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал тооцох журам;

10.1.8.ил уурхайн аюулгүй байдлын дүрэм;

10.1.9.далд уурхайн аюулгүй байдлын дүрэм;

10.1.10.баяжуулах үйлдвэрийн аюулгүй байдлын дүрэм;

10.1.11.хий, тоосны аюултай нүүрсний далд уурхайн аюулгүй байдлын дүрэм;

10.1.12.эрэл, хайгуулын ажлын аюулгүй байдлын дүрэм;

10.1.13.хайгуулын ажлын үр дүнгийн тайлан-техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах аргачлал;

10.1.14.техникийн зураг төсөл боловсруулах аргачлал;

10.1.15.ашигт малтмалын ордын жил бүрийн нөөцийн хөдөлгөөн хийх журам;

10.1.16.ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн бүртгэл, тэнцлийг хөтлөх журам;

10.1.17.технологийн аудит хийх эрх олгох, сунгах, цуцлах журам, аудит хийх аргачлал;

10.1.18.маркшейдерийн ажил, үйлчилгээг эрхлэх эрх олгох журам;

10.1.19.Монгол Улсын хилээр дээж, сорьц нэвтрүүлэх журам;

10.1.20.эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааны журам;

10.1.21.өргөдлөөр хайгуулын тусгай зөвшөөрөл олгох журам;

10.1.22.сонгон шалгаруулалтаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгох журам;

10.1.23.ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн бүртгэлийн журам;

10.1.24.геологи, уул уурхайн асуудал хариуцсан орон нутаг дахь нэгжийн үйл ажиллагааны журам;

10.1.25.үүсмэл орд ашиглах журам;

10.1.26.хайгуул, ашиглалт, баяжуулалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлангийн маягт, заавар, аргачлал;

10.1.27.мэдээллийн санг бүрдүүлэх, боловсруулах, түгээх, ашиглах, хадгалах, хамгаалах журам болон анхдагч мэдээллийн дэлгэрэнгүй жагсаалт;

10.1.28.хаалтай мэдээллийн жагсаалт;

10.1.29.уул уурхайн судалгаа, хөгжлийн төвийн үйл ажиллагааны журам;

10.1.30.уурхайн хаалтын техникийн комиссын ажиллах журам;

10.1.31.сонгон шалгаруулалтаар ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох журам.

10.1.32.уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ашиглалтад хүлээн авах журам;

10.1.33.тусгай зөвшөөрлийн талбайн хилийн маргааныг шийдвэрлэх журам;

10.1.34.Хөрөнгө оруулалтыг дэмжих зөвлөл, түүний хороодын бүрэлдэхүүн, ажиллах журам;

10.1.35.хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан тухайн жилийн нөхөн сэргээлтийн зардлыг байршуулах, хүлээн авах, буцаан олгох, зарцуулах журам;

10.1.36.улсын төсвийн хөрөнгөөр хийсэн геологи, хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөрийг тооцох журам;

10.1.37.тусгай зөвшөөрлийг шилжүүлэх, барьцаалах үйл ажиллагааны журам.

10.1.38.хайгуулын ажлын үр дүнгийн тайлан-техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах байгууллагад эрх олгох, сунгах, цуцлах журам.

10.2.Энэ хуулийн 10.1-д заасан геологи, уул уурхайн багц дүрэм, журмыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ ЭРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

### **11 дүгээр зүйл.Эрлийн үйл ажиллагаа**



11.1.Энэ хуулийн 4.1.3, 4.1.4-т заасан ажлыг улсын төсвийн хөрөнгөөр, тусгай зөвшөөрөлгүй гүйцэтгэнэ.

11.2.Ашигт малтмалын хувьд хэтийн төлөвтэй байж болох талбайд аж ахуйн нэгж энэ хуулийн 4.1.4-т заасан үйл ажиллагааг эрхлэх хүсэлт гаргасан тохиолдолд хувийн хөрөнгөөр гүйцэтгэж болно.

11.3.Энэ хуулийн 10.1.1-д заасан журмын дагуу энэ хуулийн 4.1.3, 4.1.4-т заасан ажлыг гүйцэтгэх ба Газрын хэвлийн тухай хуулийн 22, 23, 24 дүгээр зүйл, энэ хуулийн шаардлагад нийцүүлэн геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

11.4.Энэ хуулийн 4.1.4-т заасан үйл ажиллагааг хувийн хөрөнгөөр гүйцэтгэх тохиолдолд хүсэлтээ геологи, судалгааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад энэ хуулийн 10.1.1-д заасан журмын дагуу гаргана.

11.5.Геологи, судалгааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 11.4-т заасан хүсэлтийг нягталж, тухайн жилийн улсын төсвийн санхүүжилтэд уялдуулан 30 хоногийн дотор шийдвэр гаргаж эрлийн үйл ажиллагаа эрхлэх гэрээ байгуулна.

11.6.Тухайн талбайд эрлийн үйл ажиллагаа эрхлэх хүсэлтийг хоёр ба түүнээс дээш хуулийн этгээд гаргасан тохиолдолд энэ хуулийн 10.1.1-т заасан журмын дагуу хүсэлт гаргагчийн мэргэжлийн боловсон хүчин, санхүүгийн чадавх, эрлийн ажил гүйцэтгэх арга аргачлалын оновчлол, ажлын хэмжээ болон түүнтэй уялдуулан тооцсон төсөв, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын саналыг харгалзан шийдвэрлэнэ.

11.7.Энэ хуулийн 11.5, 11.6-д заасан шийдвэрийг үндэслэн эрлийн үйл ажиллагааны гэрээг 2 хүртэл жилийн хугацаагаар байгуулах ба эрх, үүргийг өөр хуулийн этгээдийн нэр дээр шилжүүлэхийг хориглоно.

11.8.Энэ хуулийн 11.1-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ энэ хуулийн 10.1.1-д заасан журмын дагуу мэдээ, мэдээллээ геологи, судалгааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тогтмол тайлагнах ба үйл ажиллагаа дуусахад гарсан үр дүнгээс үл шалтгаалан бүх төрлийн анхдагч мэдээлэл, боловсруулсан зурган болон тоон мэдээлэл, бичиглэл, үүсгэсэн геомэдээллийн санг хүлээлгэн өгнө.

11.9.Энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан хориглосон, хязгаарласан газарт энэ хуулийн 11.1-д заасан ажлыг зөвхөн улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэнэ.

11.10.Энэ хуулийн 4.1.4-т заасан ажлын үр дүнд ашигт малтмалын хэтийн төлөв нь батлагдвал тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн дунд зохион байгуулж болно.

11.11.Энэ хуулийн 11.5, 11.6-д заасан ажлын үр дүнд ашигт малтмалын хэтийн төлөвтэй нь тогтоогдсон, энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан хориглосон, хязгаарласан талбайтай давхцалгүй талбайг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сонгон шалгаруулалтын талбайд хамруулахаар Засгийн газарт хүргүүлж шийдвэрлүүлнэ.

11.12.Эрлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлгүйгээр гүйцэтгэх ба ажлын явцад газар ашигласны болон бусад төлбөр төлөхгүй.

## **12 дугаар зүйл.Эрлийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага**

12.1.Ашигт малтмалын эрдэсжсэн цэг, илрэлүүдийг үнэлэх, хэтийн төлөвийн зэрэглэлээр ангилах, дараагийн үе шатны ажил явуулах талбайг тодорхойлно.

12.2.Кадастрын бүртгэлийн мэдээллийн системээс хүчин төгөлдөр болон шүүхийн маргаантай тусгай зөвшөөрөл, засаг захиргааны нэгжийн эдэлбэр газартай давхцалтай эсэхэд шүүлт хийлгэсэн байна.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ ХАЙГУУЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

### **13 дугаар зүйл.Хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд тавигдах шаардлага**

13.1.Хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай нь дараах шаардлагыг хангасан байна:

13.1.1.нэгж талбарын дагуу тодорхойлогдсон байх;

13.1.2.хайгуулын тусгай зөвшөөрлийн солбицлыг талбайд хамрагдаж буй нэгж талбаруудын хамгийн захын нэгж талбарын булангийн солбицлоор тодорхойлох;

13.1.3.хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд хамрагдаж байгаа нэгж талбарууд нь аль нэг талаараа хоорондоо холбогдсон байх;

13.1.4.тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайтай давхцаагүй байх;

13.1.5.нэг тусгай зөвшөөрлөөр олгох талбайн хэмжээ нь 4 нэгж талбараас багагүй 13900 нэгж талбараас ихгүй байх.

### **14 дүгээр зүйл.Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох**

14.1.Хайгуулын тусгай зөвшөөрлийг өргөдлөөр болон сонгон шалгаруулалтаар дараах байдлаар олгоно:

14.1.1.геологийн судалгаа, эрлийн ажлын үр дүнгээр тогтоогдсон хэтийн төлөв бүхий талбайд хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар;

14.1.2.энэ хуулийн 14.1.1-д зааснаас бусад талбайд хайгуулын тусгай зөвшөөрлийг өргөдлөөр.

14.2.Энэ хуулийн 59.1.4-т заасан талбайн солбицлыг ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага албан ёсны цахим хуудсанд байршуулж, олон нийтэд мэдээлнэ.

14.3.Хайгуулын тусгай зөвшөөрөл хүсэгч нь өргөдлөөр хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл авах хүсэлтээ энэ хуулийн 10.1.21-д заасан журмын дагуу ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад гаргана.

14.4.Ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 14.3-т заасан өргөдлийг хүлээн авч бүртгэснээс хойш ажлын 20 өдрийн дотор хайгуулын тусгай зөвшөөрөл олгох эсэх асуудлыг хянан шийдвэрлэнэ.

14.5.Өргөдлөөр хайгуулын тусгай зөвшөөрөл олгохдоо энэ хуулийн 10.1.21-д заасан журмыг баримтална.

14.6.Ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь сонгон шалгаруулалтаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайд сонгон шалгаруулалт явуулахаас 30-аас доошгүй хоногийн өмнө сонгон шалгаруулалтын урилгыг өөрийн цахим хуудас, өдөр тутмын сонин хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ.

14.7.Сонгон шалгаруулалтад оролцох хуулийн этгээд нь хүсэлтээ энэ хуулийн 10.1.22-т заасан журмын дагуу ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад гаргана.

14.8.Сонгон шалгаруулалтаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгохдоо энэ хуулийн 10.1.22-т заасан журмыг баримтална.

14.9.Хайгуулын тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгох бөгөөд тухайн хугацаагаар 3 удаа сунгаж болно.

14.10.Ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон талаарх мэдээллийг нэгтгэн дараа сарын эхний 10 хоногт багтаан тухайн талбай байрших аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, салбарын хяналтын байгууллагад мэдэгдэж, албан ёсны цахим хуудас, өдөр тутмын сонинд нийтэлнэ.

## **15 дугаар зүйл.Хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр**

15.1.Хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийг хайгуулын талбайн гектар тутамд жилээр тооцох бөгөөд дараах хэмжээтэй байна:

15.1.1.нэгээс гурав дахь жилд 6500 төгрөг;

15.1.2.дөрвөөс зургаа дахь жилд 13000 төгрөг;

15.1.3.долоогоос ес дэх жилд 26000 төгрөг;

15.1.4.арваас арван хоёр дахь жилд 52000 төгрөг.

15.2.Тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг тусгай зөвшөөрөл олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдөрт багтаан төлнө.

15.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараа жилийн төлбөрийг тухайн тусгай зөвшөөрлийг олгосон өдрөөс эхлэн тооцож жил бүр урьдчилан төлнө.

15.4.Тусгай зөвшөөрлийн төлбөрийг тусгай зөвшөөрлийн бүртгэлд бүртгэгдсэн талбайн хэмжээг үндэслэж тогтоох бөгөөд тухайн жилд төлөх төлбөрийн хэмжээг өөрчлөхгүй.

15.5.Тусгай зөвшөөрлийн төлбөрийн баримтыг ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад бүртгүүлэх бөгөөд төлбөр төлсөн өдрийг банкны гүйлгээ хийсэн өдрөөр тооцно.

15.6.Энэ хуулийн 15.1-д заасан хугацаанд ээлжит жилийн төлбөрийг төлөөгүй бол хугацаа хэтэрсэн хоног тутамд төлөөгүй төлбөрийн үнийн дүнгийн 0.3 хувиар тооцон алданги ногдуулна.

## **16 дугаар зүйл.Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг**

16.1.Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах эрх эдэлнэ:

16.1.1.хайгуулын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайд энэ хуулийн дагуу эрэл, хайгуулын үйл ажиллагаа эрхлэх;

16.1.2.энэ хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангасны үндсэн дээр хайгуулын талбайн аль ч хэсэгт ашиглалтын тусгай зөвшөөрлийг онцгой эрхээр авах;

16.1.3.тусгай зөвшөөрлийн хугацааг энэ хуульд заасан нөхцөл, журмын дагуу сунгуулах;

16.1.4.тусгай зөвшөөрлийн талбайг холбогдох хуулийн дагуу нөхөн сэргээсэн бол өөрийн хүсэлтээр бүхэлд нь эсхүл хэсэгчлэн буцаах;

16.1.5.зохих албан татварыг төлсөн нь баримтаар нотлогдсон тохиолдолд тусгай зөвшөөрлийн талбайг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь шилжүүлэх;

16.1.6.тусгай зөвшөөрлийн гэрчилгээг шинэчлэн солиулах, нөхөн авах;

16.1.7.хил залгаа орших өөрийн эзэмшлийн тусгай зөвшөөрлийн талбайг нэгтгэх;

16.1.8.үйл ажиллагаа явуулах зорилгоор тусгай зөвшөөрлийн талбайд нэвтрэн орох, шаардлагатай барилга байгууламж барих;

16.1.9.энэ хуульд заасан эрхээ хэрэгжүүлэх зорилгоор бусдын өмчлөл, эзэмшилд байгаа газарт түүний өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрсний дагуу нэвтрэх, дайран өнгөрөх;

16.1.10.энэ хуульд заасан бусад.

16.2.Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах үүрэг хүлээнэ:

16.2.1.энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журмыг мөрдөж ажиллах;

16.2.2.хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийг тогтоосон хугацаанд бүрэн төлөх;

16.2.3.үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг батлагдсан маягтын дагуу энэ хуульд заасан хугацаанд холбогдох төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;

16.2.4.тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээлэлд өөрчлөлт орсон бол 14 хоногийн дотор ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;

16.2.5.байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, палеонтологи, археологийн судалгааг хайгуулын үйл ажиллагааг эхлүүлэхээс өмнө мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх;

16.2.6.ашигт малтмал эрэх, хайх явцад олж илрүүлсэн түүх, соёлын өвийн бүрэн бүтэн байдлыг хангаж, хуульд заасны дагуу түүх, соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлэх ба тухайн өвийг холбогдох байгууллагад хадгалуулахаар шилжүүлэх;

16.2.7.бусдын эзэмшил, ашиглалт, өмчлөлийн хөрөнгө болон түүх, соёлын дурсгалт зүйлсэд гэм хор учруулахаар бол тэдгээрийг шилжүүлэн байрлуулахтай холбогдсон зардлыг хариуцах, шаардлагатай тохиолдолд харилцан тохиролцож нөхөн төлбөр төлөх;

16.2.8.үйл ажиллагаанд шаардлагатай бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, туслан гүйцэтгэгч сонгоход шаардлага хангасан Монгол Улсын иргэн, хуулийн этгээдэд давуу эрх олгох;

16.2.9.хайгуулын ажлын анхдагч тоон өгөгдлийг хайгуулын ажлын болон үр дүнгийн тайлангийн хамт ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;

16.2.10.хайгуулын ажлын анхдагч тоон өгөгдлийг завсрын тайлан, хайгуулын үр дүнгийн тайлангийн хамт геологи, судалгааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;

16.2.11.сонгон шалгаруулалтын техникийн саналд тусгасан төсвийг хайгуулын үйл ажиллагаанд бүрэн зарцуулах;

16.2.12.тусгай зөвшөөрлийг банк, санхүүгийн байгууллагад барьцаалах тохиолдолд ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад бүртгүүлэх;

16.2.13.хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд геологийн судалгааг иж бүрэн хийж гүйцэтгэх;

16.2.14.энэ хуульд заасан бусад.

## **17 дугаар зүйл.Хайгуулын тусгай зөвшөөрөл дуусгавар болох, хүчингүй болгох, цуцлах**

17.1.Хайгуулын тусгай зөвшөөрөл дараах үндэслэлээр дуусгавар болно:

17.1.1.тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг бүхэлд нь буцаасан;

17.1.2.тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан;

17.1.3.тусгай зөвшөөрөл эзэмшигч татан буугдсан, хуваагдах, тусгаарлагдах замаар өөрчлөн байгуулагдсан.

17.2.Хайгуулын тусгай зөвшөөрлийг дараах үндэслэлээр хүчингүй болгоно:

17.2.1. тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 9.1-д заасан шаардлагыг хангахгүй болсон;

17.2.2. тусгай зөвшөөрлийг авах, сунгуулах, шилжүүлэхэд хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь шүүхээр тогтоогдсон.

17.3. Хайгуулын тусгай зөвшөөрлийг дараах тохиолдолд цуцална:

17.3.1. тусгай зөвшөөрлийн төлбөрийг энэ хуулийн 15.1-д заасан хугацаанд бүрэн төлөөгүй;

17.3.2. тухайн жилд гүйцэтгэсэн хайгуулын ажлын зардал нь энэ хуулийн 18.4-т заасан хайгуулын ажлын зардлын доод хэмжээнээс бага бол.

17.4. Ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 17.2, 17.3-т заасан үндэслэл тогтоогдсоноос хойш ажлын 10 өдрийн дотор тусгай зөвшөөрөл эзэмшигчид энэ тухай мэдэгдэх бөгөөд мэдэгдэлд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, цуцлах үндэслэлийг тодорхой заана.

17.5. Энэ хуулийн 17.4-т заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор холбогдох тайлбар болон нотлох баримтыг ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

17.6. Ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 17.5-т заасан холбогдох тайлбар болон нотлох баримтыг хянаж үндэслэлтэй бол мэдэгдлийг хүчингүй болгох, үндэслэлгүй бол тусгай зөвшөөрлийг цуцалж шийдвэрийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид ажлын 10 өдрийн дотор мэдэгдэнэ.

17.7. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийг цуцалсан шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргах эрхтэй.

17.8. Тусгай зөвшөөрөл эзэмшигч шүүхэд гомдол гаргасан тохиолдолд шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болтол тухайн талбайд шинээр тусгай зөвшөөрөл олгохгүй.

17.9. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон, цуцалсан шийдвэрийг хүчингүй болгосон шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн тусгай зөвшөөрлийн хугацааг үргэлжлүүлэн тооцно.

17.10. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон, цуцалсан, эсхүл дуусгавар болсон тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хууль болон байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн дагуу хүлээх үүргээс чөлөөлөгдөхгүй.

17.11. Ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хүчингүй болгосон, дуусгавар болгосон хайгуулын тусгай зөвшөөрлийн талаар тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, салбарын хяналтын байгууллагад сар бүр мэдэгдэж, албан ёсны цахим хуудас, өдөр тутмын сонинд нийтэлнэ.

## **18 дугаар зүйл. Хайгуулын үйл ажиллагаа эрхлэх**

18.1. Хайгуулын үйл ажиллагааг тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайд явуулна.

18.2.Энэ хуульд заасан тайлан, төлөвлөгөөг хуульд заасан хугацаанд ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

18.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын тусгай зөвшөөрлийн эхний гурван жилийн хугацаанд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг хийлгэнэ.

18.4.Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрөл олгогдсон тухайн талбайн хайгуулын ажлыг жил бүр гектар тутамд дараах хэмжээнээс багагүй зардлаар хийж гүйцэтгэнэ:

18.4.1.тусгай зөвшөөрлийн хоёроос гурав дахь жилд 3500 төгрөг;

18.4.2.тусгай зөвшөөрлийн дөрвөөс зургаа дахь жилд 7000 төгрөг;

18.4.3.тусгай зөвшөөрлийн долоогоос ес дэх жилд 35000 төгрөг;

18.4.4.тусгай зөвшөөрлийн арваас арван хоёр дахь жилд 70000 төгрөг.

18.5.Хайгуулын тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд ашигт малтмалын нөөцийг тогтоож, ордыг ашиглалтад оруулах бэлтгэл ажлын хүрээнд дараах баримт бичгийг боловсруулж, холбогдох төрийн байгууллагад энэ хуульд заасан хугацаанд хүргүүлнэ:

18.5.1.хайгуулын ажлын үр дүнгийн тайлан-техник, эдийн засгийн үндэслэл;

18.5.2.байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ;

18.5.3.уурхайн хаалтын урьдчилсан төлөвлөгөө;

18.5.4.уурхайн хаалтын үйл ажиллагааны санхүүжилтийг бүрдүүлэх эхний жилийн хаалтын санхүүжилтийн баталгаа.

18.6.Ашигт малтмалын ордын нөөцийг энэ хуулийн 10.1.7-д заасан журмын дагуу тооцоолж, үнэлсэн байна.

18.7.Хайгуулын ажлын үр дүнгийн тайланг олон улсын стандартын дагуу гүйцэтгэж болно.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ АШИГЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

**19 дүгээр зүйл.Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд тавигдах шаардлага**

19.1.Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь дараах шаардлагыг хангасан байна:

19.1.1.нэгж талбарын дагуу тодорхойлогдсон байх;

19.1.2.өргөдөл гаргагчийн хүчин төгөлдөр хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайн дотор байх;

19.1.3.ашиглалтын үйл ажиллагаа явуулахад хүрэлцэхүйц хэмжээтэй байх;

19.1.4.батлагдсан нөөцтэй байх.

## **20 дугаар зүйл.Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох**

20.1.Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас өмнө ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргах эрхтэй.

20.2.Энэ хуулийн 20.1-д заасан өргөдлийг баталсан маягтын дагуу гаргаж дараах баримт бичгийг хавсаргана:

20.2.1.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэл, хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч болон түүний хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийн талаарх мэдээлэл;

20.2.2.энэ хуулийн 18.5.1, 18.5.2, 18.5.3-т заасан баримт бичгийг хүлээн авсан тухай эрх бүхий төрийн байгууллагын шийдвэр;

20.2.3.энэ хуулийн 9.1, 18.5.4-т заасныг нотлох баримт;

20.2.4.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;

20.2.5.ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан загварын дагуу бэлтгэсэн талбайн зураг.

20.3.Ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 20.2-т заасан өргөдлийг хүлээн авч, ажлын 20 өдөрт багтаан дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

20.3.1.өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичиг нь энэ хуулийн 20.2-т заасан бүрдлийг хангаагүй бол бүрдүүлбэр хангах ажлын 10 өдөр хүртэлх хугацаа тогтоож, энэ тухайгаа албан бичгээр мэдэгдэх;

20.3.2.өргөдөл гаргагч нь энэ хуулийн 20.2-т заасан хугацаанд өргөдлийн бүрдүүлбэрийг хангаж ирүүлээгүй, бүрдүүлбэр нь хуульд заасан шаардлага хангаагүй тохиолдолд тусгай зөвшөөрөл олгохоос татгалзах;

20.3.3.өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичиг нь энэ хуулийн 20.2-т заасан шаардлагыг хангасан бол тусгай зөвшөөрөл олгохоор шийдвэрлэж, ашиглалтын тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг энэ хуулийн 15.2-т заасан хугацаанд төлүүлэх.

20.4.Хүчингүй болгосон, цуцлагдсан ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд сонгон шалгаруулалтаар ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгож болно.

20.5.Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг энэ хуулийн 10.1.31-д заасан журмын дагуу явуулна.

20.6.Сонгон шалгаруулалтын журмын дагуу ашиглалтын тусгай зөвшөөрлийг авсан хуулийн этгээд энэ хуулийн 20.2-т заасан баримт бичгийг тусгай зөвшөөрөл олгогдсоноос хойш нэг жилийн дотор ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

20.7.Ашиглалтын тусгай зөвшөөрлийг техник, эдийн засгийн үндэслэлтэй уялдуулан 10-20 жилийн хугацаагаар олгоно.



20.8.Энэ хуулийн 20.7-д зааснаас дээш хугацаагаар ордыг ашиглах тохиолдолд тусгай зөвшөөрлийн хугацааг ордын нөөцөд үндэслэн 10 жилээр хоёр удаа сунгаж болно.

20.9.Ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тухайн сард олгосон ашиглалтын тусгай зөвшөөрлийн талаарх мэдээллийг нэгтгэн дараа сарын эхний 10 хоногт багтаан тухайн талбай байрших аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, салбарын хяналтын байгууллага, татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдэгдэж, албан ёсны цахим хуудас, өдөр тутмын сонинд нийтэлнэ.

## **21 дүгээр зүйл.Ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр**

21.1. Ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөхөд энэ хуулийн 15.2, 15.3, 15.4, 15.5, 15.6-д заасан журам нэгэн адил үйлчилнэ.

21.2.Ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр нь талбайн гектар тутамд жил бүр 104000 төгрөг байх бөгөөд харин шохойн чулуу, нүүрс, дотоодын үйлдвэрлэлийн зориулалттай болон түгээмэл тархацтай ашигт малтмалын хувьд гектар тутамд 14500 төгрөг байна.

## **22 дугаар зүйл.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг**

22.1.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 16.1.3, 16.1.4, 16.1.6, 16.1.7, 16.1.8, 16.1.9-д зааснаас гадна дараах эрх эдэлнэ:

22.1.1.ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд хайгуул, олборлолт, баяжуулалтын үйл ажиллагаа явуулах;

22.1.2.энэ хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангасны үндсэн дээр ашигт малтмал болон үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг худалдах;

22.1.3.ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь албан татварыг төлсөн нь баримтаар нотлогдсон тохиолдолд тусгай зөвшөөрлийг шилжүүлэх;

22.1.4.холбогдох хууль тогтоомжийн дагуу газар, ус ашиглах;

22.1.5.үндсэн үйл ажиллагаандаа туслан гүйцэтгэгч хуулийн этгээдийг гэрээгээр ажиллуулах;

22.1.6.тусгай зөвшөөрлийн талбайд байгалийн байдлаараа оршиж байгаа бусад ашигт малтмалыг энэ хуульд заасан нөхцөл, журмын дагуу ашиглах;

22.1.7.энэ хуульд заасан бусад.

22.2.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 16.2.3, 16.2.4, 16.2.7, 16.2.8, 16.2.12-т зааснаас гадна дараах үүрэг хүлээнэ:

22.2.1.ашиглалтын үе шатанд ашигт малтмалын ордын нөөцийг сорчлохгүй, иж бүрэн ашиглах;

22.2.2.энэ хуулийн 22.1.6-д заасан ашигт малтмалыг ашиглах тохиолдолд ашигт малтмалын нөөцийг тогтоож, энэ хуульд заасан нөхцөл, шаардлагыг баримтлах;

22.2.3.ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр болон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тогтоосон хугацаанд бүрэн төлөх;

22.2.4.ашиглалтын тусгай зөвшөөрөл олгогдсоноос хойш 3 сарын дотор техникийн шаардлагын дагуу уурхайн талбайн хилийг тогтоолгож, байнгын шав тэмдэг тавих бөгөөд уурхайн талбайн хилийн хэмжилтийг геодези, маркшейдерийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээр хийлгэж, хил тогтоосон тухай актыг салбарын хяналтын байгууллага болон ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;

22.2.5.олборлосон, баяжуулсан, хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа боловсруулах үйлдвэрт тэргүүн ээлжинд зах зээлийн үнээр нийлүүлэх;

22.2.6.ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлосон үнэт металлыг Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд худалдах;

22.2.7.хаалтын үйл ажиллагааны санхүүжилтийг бүрдүүлэх, хаалтын санхүүжилтийн баталгаа байршуулах;

22.2.8.энэ хуульд заасан бусад.

22.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үндсэн үйл ажиллагаандаа туслан гүйцэтгэгчийг гэрээгээр ажиллуулсан бол энэ тухай салбарын хяналтын болон ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад бичгээр мэдэгдэж, үйл ажиллагааны тайландаа тусгасан байна.

22.4.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хууль болон байгаль орчныг хамгаалах тухай хуулиар хүлээсэн үүргээ туслан гүйцэтгэгчид гэрээгээр шилжүүлсэн нь үүрэг хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

22.5.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөр тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй харилцан тохиролцож ашигт малтмалын ордыг үйл ажиллагааны хувьд нэгдмэл байдлаар ашиглаж болох ба энэ талаарх саналаа салбарын хяналтын болон ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад бичгээр мэдэгдэнэ.

22.6.Энэ хуулийн 22.5-т заасан тохиолдолд энэ хуулийн 18.5-т заасан шаардлагыг нэгдмэл байдлаар ханган ажиллана.

22.7.Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайг хэсэгчлэн хувааж шилжүүлэхийг хориглоно.

22.8.Хууль, тогтоомж зөрчиж олборлосон, гарал үүсэл нь тодорхойгүй ашигт малтмалыг худалдан авах, баяжуулах, борлуулахыг хориглоно.

**23 дугаар зүйл.Ашиглалтын тусгай зөвшөөрөл дуусгавар болох, хүчингүй болгох, цуцлах**

23.1.Ашиглалтын тусгай зөвшөөрөл дараах үндэслэлээр дуусгавар болно:

23.1.1.тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг бүхэлд буцаасан;

23.1.2.тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан;

23.1.3.тусгай зөвшөөрөл эзэмшигч татан буугдсан, хуваагдах, тусгаарлагдах замаар өөрчлөн байгуулагдсан.

23.2.Ашиглалтын тусгай зөвшөөрлийг дараах тохиолдолд хүчингүй болгоно:

23.2.1.энэ хуулийн 9.1-д заасан шаардлага хангахгүй болсон;

23.2.2.тусгай зөвшөөрлийг авах, сунгуулах, шилжүүлэхэд хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь шүүхээр тогтоогдсон.

23.3.Ашиглалтын тусгай зөвшөөрлийг дараах тохиолдолд цуцална:

23.3.1.тусгай зөвшөөрлийн ээлжит жилийн төлбөрийг алдангийн хамт тогтоосон хугацаанд бүрэн төлөөгүй;

23.3.2.улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын зардлын нөхөн төлбөр, алдангийг гэрээнд заасны дагуу төлөөгүй;

23.3.3.ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг энэ хуульд заасан хугацаанд төлөөгүй;

23.3.4.хүрээлэн буй орчинд ноцтой хохирол учруулсан нь шүүхээр тогтоогдсон;

23.3.5.энэ хуулийн 20.6-д заасан баримт бичгийг хуульд заасан хугацаанд ирүүлээгүй.

23.4.Ашиглалтын тусгай зөвшөөрлийг цуцлахад энэ хуулийн 17.4, 17.5, 17.6, 17.7, 17.8, 17.9, 17.10, 17.11-д заасан журам нэгэн адил үйлчилнэ.

23.5.Ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага ашиглалтын тусгай зөвшөөрлийг цуцалсан бол салбарын хяналтын байгууллага, татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад сар бүр мэдэгдэж, албан ёсны цахим хуудас, өдөр тутмын сонинд нийтэлнэ.

## **24 дүгээр зүйл.Ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх**

24.1.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас томилогдсон комисс уурхайг хүлээн авч байнгын ашиглалтад оруулсны дараа ашигт малтмал ашиглах үйл ажиллагааг эхлүүлнэ.

24.2.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашиглалтын үйл ажиллагаа явуулахдаа дараах шаардлагыг хангасан байна:

24.2.1.техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийн дагуу үйл ажиллагаагаа жил бүр төлөвлөж, биелэлтийг жил бүр ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тайлагнах;

24.2.2.энэ хуулийн 10.1.3-т заасан журмыг баримтлах;

24.2.3.техник, эдийн засгийн үндэслэлд тусгагдсан технологийн дагуу явуулах;

24.2.4.ашиглалтын үйл ажиллагаа явуулахад шаардлагатай геологи, маркшейдер, ашиглалт, баяжуулалт, хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэнтэй байх;

24.2.5.уурхайн уулын ажлын ахилтаар нөөцийн блок, давхарга нээхээс дуусах хүртэлх хугацаанд маркшейдерийн хэмжилт, блок, давхаргын ул, хананы сорьцлолт хийж баримтжуулан блок, нээсэн, хаасан акт тогтмол үйлдэх;

24.3.Энэ хуулийн 24.2.4-т заасан шаардлага нь туслан гүйцэтгэгчид нэгэн адил хамаарна.

24.4.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашиглалтын үед шимт хөрс, хөрс, бага агуулгатай хүдэр, бусад ашигт малтмалыг холихгүйгээр ангилан овоолно.

24.5.Борлуулалттай холбоотой тээвэрлэлтийг эрх бүхий байгууллагын баталсан маршрутын дагуу гүйцэтгэнэ.

24.6.Ашигт малтмалын нөөцийн хэмжээ нь хайгуулын ажлын үр дүнгийн тайланд тусгагдсанаас 20 ба түүнээс дээш хувиар өөрчлөгдвөл ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ талаар холбогдох нотлох баримтыг бүрдүүлж ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ.

24.7.Энэ хуулийн 24.6-д заасан нөөцийн хөдөлгөөнийг бүртгэхдээ ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эрх бүхий хөндлөнгийн этгээдийг томилж, дүгнэлт гаргуулна.

24.8.Энэ хуулийн 24.7-д заасан дүгнэлт гаргахтай холбоотой зардлыг тусгай зөвшөөрөл эзэмшигч хариуцна.

24.9.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үйл ажиллагаагаа зогсоосон бол ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, салбарын хяналтын байгууллагад ийнхүү шийдвэрлэснээс хойш ажлын 10 өдрийн дотор бичгээр мэдэгдэнэ.

24.10.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь баяжуулалтын үйл ажиллагаа явуулах бол энэ хуульд заасан баяжуулах үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг хангаж, энэ хуулийн 27.1, 27.2-т заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

## **25 дугаар зүйл.Ашиглалтын үеийн хайгуулын үйл ажиллагаа**

25.1.Ашиглалтын үйл ажиллагааны үед ашиглалтын үеийн хайгуул, гүйцээх хайгуулыг хийж болно.

25.2.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашиглалтын үеийн хайгуулын ажлыг тухайн жилийн ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланд тусгана.

25.3.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гүйцээх хайгуулын ажлыг төлөвлөж, үр дүнгийн тайланг энэ хуулийн 10.1.13-т заасан журмын дагуу боловсруулж, тайлагнах ба хайгуулын ажлын зардлын доод хэмжээг тооцохгүй.

## **ТАВДУГААР БҮЛЭГ БАЯЖУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

### **26 дугаар зүйл.Баяжуулалтын тусгай зөвшөөрөл олгох**

26.1.Баяжуулалтын үйл ажиллагааг баяжуулалтын тусгай зөвшөөрөлтэй этгээд эрхэлнэ.

26.2.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч баяжуулалтын үйл ажиллагааг эрхлэх тохиолдолд энэ хуулийн 26.1-д заасан баяжуулалтын тусгай зөвшөөрөл шаардахгүй.

26.3.Ашиглалт, баяжуулалтын үйл ажиллагааны явцад үүсэх үүсмэл ордыг бусад этгээд ашиглах тохиолдолд баяжуулалтын тусгай зөвшөөрлийн үндсэн дээр ашиглана.

26.4.Баяжуулалтын тусгай зөвшөөрлийн өргөдөл гаргагч нь энэ хуулийн 9.1-д зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

26.4.1.технологийн, хагас үйлдвэрлэлийн туршилтыг холбогдох стандарт, арга аргачлалын дагуу хийлгэсэн байх;

26.4.2.газар ашиглах эрхийн гэрчилгээтэй байх;

26.4.3.баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны түүхий эдийн нөөцийг шийдвэрлэсэн байх;

26.4.4.үүсмэл орд ашиглагч нь нөөцийг улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн байх;

26.4.5.баяжуулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл, техникийн зураг төслийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж, дүгнэлт гаргуулсан байх;

26.4.6.байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг батлуулсан байх;

26.4.7.химийн бодисын хэрэглээг тодорхойлсон байх;

26.4.8.баяжуулах үйлдвэрийн хаалтын төлөвлөгөөг батлуулсан байх;

26.4.9.баяжуулах үйлдвэрийн хаалтын үйл ажиллагааны санхүүжилтийг бүрдүүлэх эхний жилийн хаалтын санхүүжилтийн баталгаа.

26.5.Энэ хуулийн 26.4-т заасан шаардлага хангасан тохиолдолд баяжуулалтын тусгай зөвшөөрлийг 10 жилийн хугацаагаар олгож, мөн хугацаагаар сунгаж болно.

26.6.Баяжуулалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасан хэмжээгээр төлнө.

26.7.Үүсмэл орд ашиглагч нь энэ хуулийн 26.4-т заасан шаардлага болон мөн хуулийн 10.1.25-т заасан журмыг баримтална.

## **27 дугаар зүйл.Баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг**

27.1.Баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 16.1.8, 16.1.9, 22.1.5-т зааснаас гадна дараах эрх эдэлнэ:

27.1.1.бүтээгдэхүүнийг худалдах;

27.1.2.баяжуулалтын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах;

27.1.3.зохих албан татварыг төлсөн нь баримтаар нотлогдсон тохиолдолд тусгай зөвшөөрлийг шилжүүлэх;

27.1.4.энэ хуульд заасан бусад.

27.2.Баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах үүрэг хүлээнэ:

27.2.1.үйл ажиллагааны талаар олон нийтэд мэдээлэх;

27.2.2.химийн хорт болон аюултай бодисын хаягдлыг холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу устгах;

27.2.3.баяжуулах үйлдвэрийг улсын комисст хүлээлгэн өгөх;

27.2.4.ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг бүрэн төлөх;

27.2.5.баяжуулах үйлдвэрийн хаалтын үйл ажиллагааны санхүүжилтийг бүрдүүлэх, хаалтын санхүүжилтийн баталгаа байршуулах;

27.2.6.энэ хуульд заасан бусад.

27.3.Баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гарал үүсэл нь тодорхойгүй ашигт малтмал баяжуулж, борлуулахыг хориглоно.

## **28 дугаар зүйл.Баяжуулалтын тусгай зөвшөөрөл дуусгавар болох, хүчингүй болгох, цуцлах**

28.1.Баяжуулалтын тусгай зөвшөөрөл дараах үндэслэлээр дуусгавар болно:

28.1.1.тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан;

28.1.2.тусгай зөвшөөрөл эзэмшигч татан буугдсан, хуваагдах, тусгаарлагдах замаар өөрчлөн байгуулагдсан.

28.2.Баяжуулалтын тусгай зөвшөөрлийг дараах тохиолдолд хүчингүй болгоно:

28.2.1.энэ хуулийн 9.1-д заасан шаардлага хангахгүй болсон;

28.2.2.тусгай зөвшөөрлийг авах, сунгуулах, шилжүүлэхэд хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь шүүхээр тогтоогдсон.

28.3.Баяжуулалтын тусгай зөвшөөрлийг дараах тохиолдолд цуцална:

28.3.1.ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг энэ хуульд заасан хугацаанд төлөөгүй;

28.3.2.хүрээлэн буй орчинд ноцтой хохирол учруулсан нь шүүхээр тогтоогдсон.

## **29 дүгээр зүйл.Баяжуулалтын үйл ажиллагаа эрхлэх**

29.1.Баяжуулах үйлдвэрийг зураг төслийн дагуу барьж байгуулан геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас томилогдсон улсын комисс баяжуулах үйлдвэрийг байнгын ашиглалтад оруулсны дараа баяжуулалтын үйл ажиллагааг эхлүүлнэ.

29.2.Баяжуулалтын үйл ажиллагааг эхлүүлэхээс өмнө дараах ажлыг гүйцэтгэсэн байна:

29.2.1.Барилгын тухай хуулийн 48.6-д заасан ажиллагааг хэрэгжүүлсэн байх;

29.2.2.баяжуулах үйлдвэрт ашиглах даралтат сав, хүн, ачаа өргөх, тээвэрлэх машин, өндөр хэмд ажиллах, химийн бодис бэлтгэх, ашиглах төхөөрөмжүүдэд туршилтыг гүйцэтгэж холбогдох бусад зөвшөөрлийг авсан байх;

29.2.3.химийн хорт болон аюултай бодис ашиглах зөвшөөрөл авсан байх;

29.2.4.химийн бодисын хор, аюулын мэдээллийг боловсруулж, баталгаажуулсан байх ба болзошгүй эрсдэлийг судлан тодорхойлох, түүнээс сэргийлэх арга хэмжээ болон хаягдлыг саармагжуулан устгах төлөвлөгөөтэй байх.

29.3.Баяжуулалтын үйл ажиллагаа явуулахад шаардлагатай баяжуулалтын инженер, химич, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, хаягдлын аж ахуй, байгаль орчны мэргэжилтэнтэй байна.

29.4.Баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь батлагдсан техник, эдийн засгийн үндэслэл, техникийн зураг төсөлд үндэслэн тухайн жилийн үйл ажиллагааг төлөвлөж явуулна.

29.5.Баяжуулах үйлдвэрийн бүтээгдэхүүн нь хагас боловсруулсан болон боловсруулсан бүтээгдэхүүн байна.

29.6.Бүтээгдэхүүний чанар нь Монгол Улсын эсхүл олон улсын стандартад нийцсэн байна.

29.7.Бүтээгдэхүүний чанарыг итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлтээр тодорхойлно.

29.8.Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал, техник технологи өөрчлөгдсөн тохиолдолд энэ хуулийн 29.1-д заасныг баримтална.

## **30 дугаар зүйл.Хаягдлын аж ахуй, эргэлтийн усан хангамжид тавигдах шаардлага**

30.1.Баяжуулах үйлдвэрийн хаягдлын аж ахуй, хаягдлын сангийн далан, эргэлтийн усан хангамжийн гидротехникийн байгууламжийн зураг төслийг Барилгын тухай хууль, холбогдох барилгын норм, дүрэмд заасны дагуу боловсруулна.

30.2.Хаягдлын аж ахуй, эргэлтийн усан хангамжийн төрөл, хийц, байршлыг төлөвлөхдөө дараах ерөнхий шаардлагыг баримтална:

30.2.1.өндөршил, хэвгийжил, уур амьсгал, инженер-геологи, гидрогеологи, гидрологи, биологийн зэрэг бүс нутгийн газар зүй, байгалийн бусад нөхцөл байдлыг харгалзсан байх;

30.2.2.хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийг харгалзсан байх;

30.2.3.далангийн техникийн байдал, байгалийн хүчин зүйлийн нөлөөг тогтмол хянах боломжтой байх;

30.2.4.хаягдлын сангийн далангийн хамгаалалт, хашилт тогтвортой байх;

30.2.5.үерийн уснаас хамгаалах боломжтой байх;

30.2.6.ариутгах татуургын сүлжээнд нийлүүлсэн усыг эргэлтийн усан хангамжаар нөхөн ашиглах.

30.3.Байгалийн аюул, гамшиг болсон тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хаягдлын сангийн далангийн байдалд иж бүрэн үзлэгийг зураг төсөлд тусгасан зааврын дагуу хийж гүйцэтгэнэ.

30.4.Хаягдлын сангийн усны химийн найрлагыг хүлцэх хэмжээнд байгаа, эсэх талаар мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулна.

30.5.Хаягдлын сангийн далангийн ашиглалтын байдал, хаялга бүрдүүлэх байдал, дараагийн шатны өргөтгөлийн суурь үүсгэж байгаа байдалд тогтмол хугацаанд зохиогчийн хяналтыг хийлгэнэ.

30.6.Хаягдлын аж ахуйн стандарт, шаардлагыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, стандарт хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаар батлуулна.

## **ЗУРГАДУГААР БҮЛЭГ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ШИЛЖҮҮЛЭХ, БАРЬЦААЛАХ**

### **31 дүгээр зүйл.Тусгай зөвшөөрлийг шилжүүлэх**

31.1.Хайгуул, ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Иргэний хууль, Компанийн тухай, Нөхөрлөлийн тухай хуульд заасны дагуу нэгдэх, нийлэх хэлбэрээр өөрчлөн байгуулагдсан тохиолдолд шинээр бий болсон эрх хүлээн авагчид, түүнчлэн хараат, охин компани нь толгой компанидаа, толгой компани нь хараат, охин компанидаа тусгай зөвшөөрлийг шилжүүлж болно.

31.2.Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь эрэл, хайгуулын талаархи анхдагч материал, тайлан зэрэг мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу худалдаж зохих албан татвар төлсөн нь баримтаар нотлогдсон тохиолдолд түүний эзэмшилд байсан тусгай зөвшөөрлийг худалдан авагчид нь шилжүүлж болно.

31.3.Ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхай, үйлдвэрийг техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, баримт бичгийн хамт холбогдох хууль тогтоомжийн дагуу худалдаж зохих албан татвар төлсөн нь баримтаар нотлогдсон



тохиолдолд түүний эзэмшилд байсан тусгай зөвшөөрлийг худалдан авагчид нь шилжүүлж болно.

31.4.Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уг зөвшөөрлөөр олгогдсон талбайн тодорхой хэсгийг энэ хуульд заасан нөхцөл, шаардлага, журмын дагуу тусгай зөвшөөрөл эзэмших эрх бүхий бусад этгээдэд шилжүүлж болно.

31.5.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Иргэний хууль, Компанийн тухай, Нөхөрлөлийн тухай хуульд заасны дагуу хуваагдах, тусгаарлагдах замаар өөрчлөн байгуулагдсан тохиолдолд уг тусгай зөвшөөрлийг төрийн захиргааны байгууллагад буцааж өгнө.

31.6.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 31.5-д зааснаар өөрчлөн байгуулагдсан боловч энэ хуулийн 9.1-д заасан шаардлагыг хадгалсан бол уг тусгай зөвшөөрлийг дахин авах давуу эрх эдэлнэ.

31.7.Тусгай зөвшөөрлийг шилжүүлэх, шилжилт хөдөлгөөнийг бүртгэх, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг шилжихтэй холбоотой харилцааг энэ хуулийн 10.1.37-д заасан журмаар зохицуулна.

## **32 дугаар зүйл.Тусгай зөвшөөрлийг барьцаалах**

32.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашигт малтмалын хайгуул, ашиглалт, баяжуулалтын үйл ажиллагаа явуулахад шаардагдах санхүүжилт олох, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх зорилгоор тусгай зөвшөөрлийг геологийн судалгааны мэдээлэл, хайгуулын ажлын үр дүнгийн тайлан-техник, эдийн засгийн үндэслэл зэрэг холбогдох баримт бичиг болон хууль тогтоомжоор барьцаалахыг хориглоогүй эд хөрөнгийн хамтаар банк, банк бус санхүүгийн байгууллагад барьцаалж болно.

32.2.Ашигт малтмалын хайгуул, ашиглалт, баяжуулалтын үйл ажиллагаа явуулахад шаардагдах санхүүжилт олох, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэхээс бусад зорилгоор тусгай зөвшөөрлийг барьцаалах, санхүүжилтийг зориулалтын бусаар зарцуулахыг хориглоно.

32.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь барьцааны гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхээргүй, эсхүл энэ хуульд зааснаар тусгай зөвшөөрлийн хугацаа дуусгавар болох нөхцөл бүрдсэн тохиолдолд ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ тухай барьцаалагчид мэдэгдэх бөгөөд барьцаалагч нь мөн хуульд заасан эрх бүхий этгээдэд тусгай зөвшөөрлийг шилжүүлэх саналыг тэргүүн ээлжинд гаргах эрхтэй.

32.4.Тусгай зөвшөөрлийг барьцаалах, барьцааны гэрээг бүртгэх, бүртгэлээс хасах, барьцааны гэрээний дагуу тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэхтэй холбоотой харилцааг энэ хуулийн 10.1.37-д заасан журмаар зохицуулна.

## **ДОЛДУГААР БҮЛЭГ УУРХАЙ, ҮЙЛДВЭРИЙН ХААЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

### **33 дугаар зүйл.Хаалтын үйл ажиллагаа, түүний төрөл, төлөвлөлт**

33.1.Ашигт малтмал ашиглалт, баяжуулалтын үйл ажиллагааг энэ хуулийн 10.1.4-т заасан журам, аргачлалын дагуу боловсруулж батлуулсан хаалтын төлөвлөгөөтэйгөөр гүйцэтгэнэ.

33.2.Хаалтын үйл ажиллагаа нь дараах төрөлтэй байна:

33.2.1.техник-эдийн засгийн үндэслэлд заасны дагуу уурхайн олборлолт болон баяжуулалтын үйл ажиллагааг дахин сэргээхгүй байдлаар хаах төлөвлөгөөт хаалт;

33.2.2.давагдашгүй хүчин зүйл тохиолдсоны улмаас үйл ажиллагааг үргэлжлүүлэх боломжгүй болсон эсхүл ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч дампуурсаны улмаас техник, эдийн засгийн үндэслэлд заасан хугацаанаас өмнө ашигт малтмал олборлох болон баяжуулах үйл ажиллагааг дахин сэргээхгүй байдлаар хаах гэнэтийн хаалт;

33.2.3.зах зээлийн нөхцөл байдал хүндэрсэн, ашиглалтын явцад хайгуулаар тогтоогдсон нөөц батлагдаагүй буюу нэмэлт хайгуул хийх шаардлагатай болсон, уул-техникийн, гидрогеологийн нөхцөл хүндэрсэн, ашиглалт, баяжуулалтын технологийн горим алдагдсан болон технологийн шинэчлэл хийх нөхцөл, шаардлага үүссэн тохиолдолд ашигт малтмал олборлох болон баяжуулах үйл ажиллагааг дахин сэргээх боломжтой байдлаар хаах түр хаалт.

33.3.Хаалтын төлөвлөгөөг дор дурдсан үе шатуудад дараах байдлаар боловсруулж баталгаажуулна:

33.3.1.ашиглалтын тусгай зөвшөөрөл авахын өмнө хайгуулын ажлын үр дүнгийн тайлан-техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд үндэслэн уурхайн хаалтын урьдчилсан төлөвлөгөөг;

33.3.2.баяжуулалтын тусгай зөвшөөрөл авахын өмнө баяжуулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд үндэслэн баяжуулах үйлдвэрийн хаалтын урьдчилсан төлөвлөгөөг;

33.3.3.ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлосон ашигт малтмал, баяжуулах үйлдвэрийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн болон гүйцэтгэсэн явцын нөхөн сэргээлтийн үзүүлэлт, зардлыг тусган энэ хуулийн 33.3.1, 33.3.2-т заасан хаалтын урьдчилсан төлөвлөгөөг уурхайн олборлолтын болон баяжуулах үйлдвэрийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эхлүүлснээс хойш 5 жил тутам нарийвчилан тодотгоно;

33.3.4.техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд өөрчлөлт орсон тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хаалтын төлөвлөгөөг энэ хуулийн 33.3.3-т заасан мөчлөгтэй уялдуулан тухай бүр 2 жилээс илүүгүй хугацааны дотор тодотгоно;

33.3.5.ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхайн олборлолтын үйл ажиллагааг зогсоохоор, баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь баяжуулах үйлдвэрийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг зогсоохоос тус бүр 1 жилээс доошгүй хугацааны өмнө хаалтын төлөвлөгөөний сүүлийн тодотголыг хийнэ;

33.3.6.энэ хуулийн 33.2.2, 33.2.3-т заасан тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрийн санаачлагаар эсхүл ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага шаардсаны дагуу холбогдох хаалтын төлөвлөгөөг тодотгож болно.

33.4.Хаалтын төлөвлөгөөг энэ хуулийн 33.3-т заасны дагуу тодотгоход уурхайн хувьд олборлолтын үйл ажиллагааны, баяжуулах үйлдвэрийн хувьд үйлдвэрлэлийн үйл ажиллагааны бодит гүйцэтгэл, гүйцэтгэсэн явцын нөхөн сэргээлтийн зардлыг хаалтын санхүүжилтийн тооцооллын тодотголд хамруулна.

33.5.Энэ хуулийн 10.1.4-т заасан уурхай, баяжуулах үйлдвэрийн хаалтын үйл ажиллагааны журам, хаалтын төлөвлөгөөг боловсруулах аргачлалаар хаалтын төлөвлөгөөний агуулга, тавигдах шаардлагыг энэ хуулийн 31.3-т заасан хаалтын төлөвлөгөөг боловсруулах үе шат болон хамаарах ашигт малтмалын төрөл, олборлолтын арга хэлбэрээс хамааруулж нарийвчлан тогтооно.

33.6.Хаалтын төлөвлөгөөг энэ хуулийн 69.6-д заасан эрх бүхий мэргэшсэн мэргэжилтнээр гүйцэтгүүлнэ.

33.7.Энэ хуулийн 33.3.5-д заасан хаалтын төлөвлөгөөний сүүлийн тодотголыг боловсруулах явцад төслийг тухайн сум, дүүрэг оршин суугч иргэдэд танилцуулж, саналыг нь авна.

33.8.Ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хаалтын төлөвлөгөөг дор дурдсан хугацааны дотор хянан батална:

33.8.1.энэ хуулийн 33.3.1, 33.3.2-т заасан хаалтын урьдчилсан төлөвлөгөөг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор;

33.8.2.энэ хуулийн 33.3.3, 33.3.4, 33.3.6-д заасан хаалтын төлөвлөгөөний тодотголыг хүлээн авснаас хойш 45 хоногийн дотор;

33.8.3.энэ хуулийн 33.3.5-д заасан хаалтын төлөвлөгөөний сүүлийн тодотголыг хүлээн авснаас хойш 60 хоногийн дотор.

33.9.Ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хаалтын төлөвлөгөө нь шаардлага хангаагүй гэж үзвэл буцаах шийдвэрийг үндэслэлийн хамт хүсэлт гаргагчид хүргүүлнэ.

### **34 дүгээр зүйл.Хаалтын үйл ажиллагааны санхүүжилтийг бүрдүүлэх**

34.1.Хаалтын үйл ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэрийг дараах байдлаар бүрдүүлнэ:

34.1.1.энэ хуулийн 33.3.1-д заасан уурхайн хаалтын урьдчилсан төлөвлөгөөний хүрээнд уурхай байгуулах байгууламжийн үйл ажиллагааны нөхөн сэргээлтэд шаардагдах зардлын хэмжээгээр;

34.1.2.энэ хуулийн 33.3.2-т заасан баяжуулах үйлдвэрийн хаалтын урьдчилсан төлөвлөгөөний хүрээнд баяжуулах үйлдвэрийн барилга угсралтын үйл ажиллагааны нөхөн сэргээлтэд шаардагдах зардлын хэмжээгээр;

34.1.3. уурхайн техник эдийн засгийн үндэслэлд заасан олборлолтын үйл ажиллагаа явуулах нийт хугацаа нь 3 хүртэл жилийн хугацаатай бол тухайн уурхайг ашиглалтад оруулахаас өмнө уурхайн хаалтын үйл ажиллагааны зардлын нийт хэмжээгээр;

34.1.4. баяжуулах үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэлд заасан үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулах нийт хугацаа нь 3 хүртэл жилийн хугацаатай бол тухайн баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулахаас өмнө баяжуулах үйлдвэрийн хаалтын үйл ажиллагааны зардлын нийт хэмжээгээр;

34.1.5. уурхай, баяжуулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлд заасан олборлох болон баяжуулах үйл ажиллагаа явуулах нийт хугацаа нь энэ хуулийн 34.1.4-т заасан хугацаанаас дээш хугацаатай бол хаалтын үйл ажиллагааны зардлыг энэ хуулийн 34.3-т заасны дагуу тооцсон жил бүр нэмэгдүүлэх хэмжээгээр;

34.2. Энэ хуулийн 34.1.5-д заасан тухайн жилд нэмж бүрдүүлэх хаалтын санхүүжилтийн дүнг энэ хуулийн 34.3-т заасан суурь хуваарь болон хаалтын төлөвлөгөөний сүүлийн тодотголд заасан дүнгээс тухайн жилийн олборлолтын гүйцэтгэлийг харгалзан нөхөн сэргээлтийн зардлыг хасч тодорхойлно.

34.3. Ашигт малтмалын ордод олборлолтын үйл ажиллагаа явуулах, баяжуулах үйлдвэрийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулах төслийн хугацаанаас хамаарч тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зүгээс олборлолт, баяжуулалтын үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш жил бүр бүрдүүлэх хаалтын үйл ажиллагааны санхүүжилтийн тооцооллыг дор дурдсан суурь хуваарьт заасан хувь хэмжээг үндэслэн тооцоолно:

		Жил бүр бүрдүүлэх хаалтын санхүүжилт (хувиар)																			
		1 дэх жил	2 дахь жил	3 дахь жил	4 дэх жил	5 дахь жил	6 дахь жил	7 дахь жил	8 дахь жил	9 дэх жил	10 дахь жил	11 дэх жил	12 дахь жил	13 дахь жил	14 дэх жил	15 дахь жил	16 дахь жил	17 дахь жил	18 дахь жил	19 дэх жил	20 дахь жил
Олборлолт, баяжуулалтын үйл ажиллагаа явуулах техник, эдийн засгийн үндэслэлд заасан нийт хугацаа (жилээр)	4	11.1	33.3	55.6	-																
	5	6.3	18.7	31.3	43.7	-															
	6	6.3	18.7	25.0	25.0	25.0	-														
	7	3.0	12.3	18.0	22.2	22.2	22.3	-													
	8	2.8	3.0	10.2	17.3	22.2	22.2	22.3	-												
	9	2.0	2.8	4.0	9.2	15.3	22.2	22.2	22.3	-											
	10	2.0	5.5	9.5	13.8	13.8	13.8	13.8	13.9	13.9	-										
	11	1.6	2.0	5.0	9.0	13.7	13.7	13.7	13.7	13.8	13.8	-									
	12	1.2	1.6	2.0	5.0	8.8	13.5	13.5	13.6	13.6	13.6	13.6	-								
	13	1.0	3.0	5.0	6.3	8.0	9.5	9.5	9.5	9.5	9.5	9.6	9.6	-							
	14	1.0	3.0	5.0	6.3	8.0	8.3	8.3	8.3	8.3	8.3	8.3	8.4	8.4	-						
	15	1.0	1.0	2.0	5.0	6.3	8.0	8.3	8.3	8.3	8.3	8.3	8.3	8.5	8.5	-					
	16	1.0	1.0	2.0	5.0	6.3	8.0	8.4	8.4	8.4	8.4	8.5	8.5	8.5	8.6	8.6	-				
	17	1.0	1.0	2.0	5.0	6.3	7.5	7.5	7.5	7.5	7.5	7.6	7.6	7.6	7.7	7.7	7.7	-			
	18	1.0	1.0	2.0	5.0	6.3	7.0	7.0	7.0	7.0	7.0	7.0	7.0	7.1	7.1	7.1	7.2	7.2	-		
	19	1.0	1.0	2.0	5.0	6.3	6.5	6.5	6.5	6.5	6.5	6.5	6.5	6.5	6.5	6.5	6.5	6.6	6.6	-	
	20	1.0	1.0	2.0	5.0	5.6	5.6	5.6	5.6	5.6	5.6	5.6	5.7	5.7	5.7	5.7	5.8	5.8	5.9	5.9	-

34.4. Ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн уурхайн олборлолтын болон баяжуулалтын үйл ажиллагаа явуулах техник, эдийн засгийн үндэслэлд заасан хугацаа нь 21 болон түүнээс дээш жилийн хугацаанд үргэлжлэх тохиолдолд жил бүр бүрдүүлэх хаалтын үйл ажиллагааны санхүүжилтийн суурь хуваарийг энэ хуулийн 34.2-т заасан хуваарийн 20 жил үйл ажиллагаа явуулах

нөхцөлөөр тодорхойлсон хуваарьтай жишиж хувь тэнцүүлэн тооцоолох замаар холбогдох хувь хэмжээг тодорхойлно.

34.5.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хаалтын үйл ажиллагааны санхүүжилтийн бүрдүүлэлтийг нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартын дагуу үнэн зөвөөр бүртгэх ба тухайн жилд бүрдүүлсэн санхүүгийн эх үүсвэрийг тухайн жилийн уулын ажлын болон баяжуулах үйлдвэрийн тайланд тусган тайлагнана.

34.6.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 34.1, 34.2-т тухай бүр бүрдүүлбэл зохих санхүүжилтийн дүнг дутуу бүрдүүлсэн тохиолдолд дутуу дүнгийн хэмжээгээр хаалтын санхүүжилтийн баталгаа гаргана.

34.7.Энэ хуулийн 34.6-д заасан хаалтын санхүүжилтийн баталгааг дор дурдсан дарааллын дагуу гаргана:

34.7.1.системийн нөлөө бүхий банкны баталгаа;

34.7.2.Монгол Улсын Засгийн газраас тогтоосон бусад байдлаар.

34.8.Энэ хуулийн 34.7.1-д заасан баталгааг ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өмнөөс гуравдагч этгээд гаргаж болно.

34.9.Хаалтын санхүүжилтийн баталгааг бүртгэх, хадгалах, өөрчлөх, чөлөөлөхтэй холбоотой журмыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

### **35 дугаар зүйл.Хаалтын үйл ажиллагааны хэрэгжилт, тайлагнал**

35.1.Ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилд гүйцэтгэсэн явцын нөхөн сэргээлтийн үйл ажиллагааны гүйцэтгэл, тухайн жилийн байдлаар бүрдүүлбэл зохих хаалтын санхүүжилтийн бүрдүүлэлтийн байдлыг тухайн жилийн уулын ажлын гүйцэтгэлийн тайланд тусган холбогдох санхүүгийн баримтыг хавсарган ирүүлнэ.

35.2.Ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь холбогдох техник-эдийн засгийн үндэслэл, хаалтын төлөвлөгөөний сүүлийн тодотголд заасны дагуу олборлолтын болон баяжуулах үйлдвэрийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг зогсоосны үндсэн дээр хаалтын үйл ажиллагааг эхлүүлэх бөгөөд энэ тухай ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт мэдэгдэнэ.

35.3.Ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь 35.2-т заасан хаалтын үйл ажиллагааны жилийн тайланг ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор хүргүүлнэ.

35.4.Ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хаалтын төлөвлөгөөний гүйцэтгэлийн хувь хэмжээгээр хаалтын санхүүжилтийн баталгааг чөлөөлнө.

35.5.Ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хаалтын сүүлийн тодотголд заасан хаалтын дараах хяналт, шинжилгээ, арчилгаа тордолтын ажлаас бусад ажлыг гүйцэтгэж дууссанаас хойш 2 сарын дотор хаалтын үйл ажиллагааны нэгдсэн тайланг ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн

захиргааны байгууллагад хүргүүлж, хаалтын техникийн комисс ажиллуулах хүсэлтийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

35.6.Ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ирүүлсэн уурхайн хаалтын техникийн комисс ажиллуулах хүсэлтийг хүлээн авсан даруйд уурхайн хаалтын техникийн комиссыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн сайд томилно.

35.7.Хаалтын техникийн комиссын бүрэлдэхүүнд дараах байгууллагын төлөөллийг оруулна:

35.7.1.ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага;

35.7.2.геологи, уул уурхайн асуудал хариуцсан орон нутаг дахь нэгж;

35.7.3.байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

35.7.4.тухайн сум, дүүргийн байгаль орчны асуудал хариуцсан нэгж;

35.7.5.тухайн аймаг, нийслэлийн газрын асуудал хариуцсан нэгж;

35.7.6.тухайн сум, дүүргийн Засаг даргын тамгын газар;

35.7.7.энэ хуулийн 69.6-д заасан хаалтын асуудлаар мэргэшсэн мэргэжилтэн.

35.8.Хаалтын техникийн комисс уурхай, баяжуулах үйлдвэрийн хаалтын талаар дүгнэлт гаргаж, тусгай зөвшөөрлийн талбай, баяжуулах үйлдвэрийн зориулалтаар олгогдсон газрыг орон нутагт хүлээлгэн өгсөн тухай болон уурхай, баяжуулах үйлдвэрийг хаасан тухай актыг үйлдэнэ.

35.9.Хаалтын техникийн комисс нь уурхай, үйлдвэрийн хаалтын төлөвлөгөөний биелэлт хангалтгүй гэж дүгнэсэн тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчид хугацаатай үүрэг даалгаврыг өгөх бөгөөд тусгай зөвшөөрөл эзэшигч нь өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангаснаар хаалтын техникийн комиссыг дахин ажиллуулна.

35.10.Ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 35.9-д заасан дүгнэлт болон актыг үндэслэн хаалтын гэрчилгээ олгож хаалтын санхүүжилтийн баталгааг хаалтын дараах хяналт, арчилгаа, тордолтын зардлыг хассан дүнгээр чөлөөлнө.

35.11.Тусгай зөвшөөрөл эзэмшигчид хаалтын гэрчилгээ олгогдсон нь уурхай, үйлдвэрийн хаалтын дараах хяналт, арчилгаа тордолтын үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

35.12.Ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхай, баяжуулах үйлдвэрийн хаалтын төлөвлөгөөгөөр хүлээсэн үүргээ бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн гүйцэтгэх чадваргүй болсон эсхүл хаалтын ажлын үр дүн уурхай, үйлдвэрийн хаалтын төлөвлөгөөнд заасан түвшинд хүргэх боломжгүй болсон тохиолдолд энэ тухай холбогдох үндэслэл, тайлбарын хамт ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ.

35.13.Хаалтын техникийн комисс нь уурхай, баяжуулах үйлдвэрийн хаалтын төлөвлөгөөний биелэлтийг тусгай зөвшөөрөл эзэмшигч хангаж чадахгүй болсон гэж үзсэн тохиолдолд энэ тухай дүгнэлт гаргаж, тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тус тус хүргүүлнэ.

35.14.Тусгай зөвшөөрөл эзэмшигч энэ хуулийн 33.13-т заасан дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн тохиолдолд энэ тухай өөрсдийн үндэслэл бүхий тайлбарыг дүгнэлт хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

35.15.Энэ хуулийн 35.13, 35.14-т заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь тусгай зөвшөөрөл эзэмшигчид хаалтын үйл ажиллагааг зохих журмын дагуу гүйцэтгэх хугацаатай үүрэг өгөх бөгөөд уг хугацаанд гүйцэтгэлийг зохих журмаар хангаагүй бол хаалтын үйл ажиллагааг эрх бүхий гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулна.

35.16.Энэ хуулийн 35.15-т заасан үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн бүрдүүлсэн санхүүжилтийн эх үүсвэр, гаргасан хаалтын санхүүжилтийн баталгаа хүрэлцэхгүй болсон тохиолдолд шаардагдах нэмэлт хөрөнгийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс үл маргах журмаар гаргуулна.

### **36 дугаар зүйл.Хаалтын дараах хяналт шинжилгээ, арчилгаа, тордолт**

36.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хаалтын дараах хяналт шинжилгээ, арчилгаа, тордолтыг хаалтын төлөвлөгөөний сүүлийн тодотголд заасан хугацаа, давтамжийн дагуу гүйцэтгэж, явцын мэдээг хагас жил тутам ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон харьяа сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт хүргүүлнэ.

36.2.Энэ хуулийн 36.1-д заасан хаалтын үйл ажиллагааг эрх бүхий мэргэшсэн мэргэжилтэн, хуулийн этгээдээр гүйцэтгүүлж болно.

36.3.Энэ хуулийн 36.2-т заасны дагуу хаалтын үйл ажиллагааг бусад этгээдээр гүйцэтгүүлэх нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийг хаалтын дараах хяналт шинжилгээ, арчилгаа, тордолтыг зохих ёсоор гүйцэтгэх үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

36.4.Хаалтын дараах хяналт шинжилгээ, арчилгаа, тордолтын хэрэгжилтэнд ашигт малтмалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, тухайн сум, дүүргийн Засаг даргын тамгын газраас хяналт тавина.

36.5.Ашигт малтмалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас хаалтын дараах хяналт шинжилгээ, арчилгаа, тордолтын хэрэгжилт хангагдсан гэж үзсэн тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хаалтын дараах хяналт шинжилгээ, арчилгаа, тордолт, хяналт шинжилгээний ажилтай холбоотой гаргасан хаалтын санхүүжилтийн баталгааг чөлөөлнө.

36.6.Ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан нь уурхай, баяжуулах үйлдвэрийг хаах, хаалтын дараах хяналт шинжилгээ, арчилгаа, тордолттой холбоотой үүргээс тусгай зөвшөөрөл эзэмшигчийг чөлөөлөх үндэслэл болохгүй.

## **НАЙМДУГААР БҮЛЭГ ЧУХАЛ АШИГТ МАЛТМАЛ**

### **37 дугаар зүйл. Чухал ашигт малтмалд тавигдах шаардлага**

37.1. Чухал ашигт малтмалын жагсаалтыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын өргөн мэдүүлснээр Засгийн газар батална.

37.2. Энэ хуулийн 37.1-д заасан ашигт малтмалыг эрэх, хайх, ашиглах, баяжуулах үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн арга хэмжээг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.5.3, 6.5.7-д заасан хөтөлбөрт тус тус тусгаж хэрэгжүүлнэ.

37.3. Энэ хуулийн 37.2-т заасан арга хэмжээ нь салбар, салбар хоорондын уялдааг хангах, бүс, орон нутгийг хөгжүүлэх, өндөр технологийн болон боловсруулах үйлдвэр байгуулах, хөрөнгө оруулалтыг дэмжихэд чиглэсэн байна.

### **38 дугаар зүйл. Чухал ашигт малтмалын эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагааны онцлог зохицуулалт**

38.1. Чухал ашигт малтмалын хэтийн төлөвийг тодорхойлох, нөөц өсгөх зорилгоор геологийн судалгаа, хайгуулын ажлыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жил бүр төлөвлөнө.

38.2. Энэ хуулийн 8.1.1-д заасан хориглосон газарт чухал ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулах бол тухайн газрыг улсын тусгай хамгаалалтаас гаргах саналыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Засгийн газарт хүргүүлнэ.

38.3. Энэ хуулийн 8.4.1, 8.4.2, 8.4.3-т заасан хориглосон, хязгаарласан газарт чухал ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулах бол геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тухайн газрыг тусгай хэрэгцээнээс гаргах саналыг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ.

38.4. Энэ хуулийн 38.2, 38.3-т заасан шийдвэрийг үндэслэн чухал ашигт малтмал хайх, ашиглах үйл ажиллагааг энэ хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу эрхэлж болно.

## **ЕСДҮГЭЭР БҮЛЭГ ХАЙГУУЛЫН АЖЛЫН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН-ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ, ТЕХНИКИЙН ЗУРАГ ТӨСӨЛ**

### **39 дүгээр зүйл. Хайгуулын ажлын үр дүнгийн тайлан-техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах шаардлага**

39.1. Хайгуулын ажлын үр дүнгийн тайлан-техник, эдийн засгийн үндэслэлийг хайгуулын тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд боловсруулна.

39.2. Техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулахдаа хайгуулын ажлын үр дүнгээр тогтоогдсон нөөцийг иж бүрэн ашиглах, техник, технологийн оновчтой шийдлийг гаргах, эдийн засгийн үр ашигтай байх хувилбараар тооцно.



39.3.Хайгуулын ажлын үр дүнгийн тайлан-техник эдийн засгийн үндэслэлийг энэ хуулийн 10.1.13-т заасан аргачлалын дагуу боловсруулна.

39.4.Хайгуулын ажлын үр дүнгийн тайлан-техник, эдийн засгийн үндэслэл нь дараах шаардлагыг хангасан байна.

39.4.1.геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд боловсруулсан байх;

39.4.2.хайгуулын болон уурхай, үйлдвэрийн үйл ажиллагааны бүх үе шатыг хамруулсан байх;

39.4.3.орд, уурхай, үйлдвэрийн газрыг бүрэн хамарсан байр зүйн зурагт үндэслэн уурхайн ерөнхий төлөвлөлтийн зураг, зүсэлт, тооцооллыг холбогдох стандартын дагуу маркшейдерийн ажил, үйлчилгээ эрхлэх эрх бүхий этгээд гүйцэтгэсэн байх;

39.5.Хайгуулын ажлын үр дүнгийн тайлан-техник, эдийн засгийн үндэслэлийг уурхай, үйлдвэрийн үйл ажиллагааны төлөвлөлтийг үйлдвэрлэлийн нийт нөөцийг ашиглах хугацаагаар ерөнхийлөн төлөвлөсөн төсөөлөл гаргаж, 5 жилээр нарийвчлан төлөвлөж, энэ хуулийн 10.1.13-т заасан аргачлалын дагуу тодотгоно.

39.6.Хайгуулын ажлын үр дүнгийн тайлан-техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулсан хуулийн этгээд нь түүний үнэн зөв, үндэслэл бүхий байдлыг захиалагчийн өмнө хариуцна.

39.7.Хайгуулын ажлын үр дүнгийн тайлан-техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт гаргасан шинжээч нь өөрийн гаргасан дүгнэлтийн үнэн зөвийг хариуцна.

39.8.Хайгуулын ажлын үр дүнгийн тайлан-техник, эдийн засгийн үндэслэлийг хүлээн авах, хянах, баталгаажуулах үйл ажиллагааг энэ хуулийн 10.1.20-д заасан журмаар зохицуулна.

39.9.Баяжуулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл нь дараах шаардлагыг хангасан байна.

39.9.1. энэ хуулийн 10.1.13-т заасан журмын дагуу боловсруулсан байх;

39.9.2.энэ хуулийн 26.4.1-д заасан туршилтад үндэслэсэн байх;

39.9.3.техник, технологийн сонголтыг үр ашигт суурилсан оновчлолоор тооцоолсон байх;

39.9.4.энэ хуулийн 26.4.3, 26.4.4-т заасан түүхий эдийн нөөцөд тулгуурласан байх.

#### **40 дүгээр зүйл.Техникийн зураг төсөл зохиоход тавигдах шаардлага**

40.1.Техникийн зураг төслийг энэ хуулийн 10.1.14-д заасан аргачлалын дагуу боловсруулж, техникийн зураг төслийн хүлээн авах, хянах, баталгаажуулах үйл ажиллагааг энэ хуулийн 10.1.20-д заасан журмаар зохицуулна.

40.2.Техникийн зураг төслийг энэ хуулийн 39.4.1-д заасан тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд боловсруулна.

40.3.Уурхайн техникийн зураг төсөл нь дараах шаардлагыг хангасан байна:

40.3.1.хайгуулын ажлын үр дүнгийн тайлан-техник, эдийн засгийн үндэслэлд үндэслэж боловсруулсан байх;

40.3.2.талбайн геологи, геофизик, геотехник, гидрогеологи, гидрологи, технологийн туршилт болон бусад судалгааны материалыг үндэслэж боловсруулсан байх.

40.4.Баяжуулах үйлдвэрийн техникийн зураг төсөл нь дараах шаардлагыг хангасан байна:

40.4.1.баяжуулах үйлдвэрийн барилга байгууламжийг 1:1000-аас багагүй масштабтай байр зүйн зурагт оновчтой байршуулсан байх;

40.4.2.холбогдох хууль, дүрэм, стандартуудын шаардлагыг хангасан байх.

40.5.Баяжуулах үйлдвэрийн хаягдлын аж ахуй, усан сангийн далан, эргэлтийн усан хангамжийн гидротехникийн барилгын техникийн зураг төслийг боловсруулахдаа Барилгын тухай хууль, холбогдох барилгын норм, дүрмийг удирдлага болгоно.

40.6.Баяжуулах үйлдвэрийн техникийн зураг төсөлд зохиогчийн хяналтыг тогтмол хийлгэнэ.

## **АРАВДУГААР БҮЛЭГ АШИГТ МАЛТМАЛЫН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР**

### **41 дүгээр зүйл.Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр**

41.1.Доор дурдсан этгээд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байна:

41.1.1.ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч;

41.1.2.ашигт малтмал экспортолсон этгээд;

41.1.3.Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд алт тушаасан этгээд.

41.2.Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдох орлогыг дараах зарчмаар тооцно:

41.2.1.Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд худалдсан, экспортлосон үнэт металлын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдох орлогыг Монголбанкнаас зарласан уг үнэт металлын тухайн өдрийн авах үнийг үндэслэн;

41.2.2.зэс, цайр, цагаан тугалга, хар тугалга, молибдени, гянтболдын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдох орлогыг Лондонгийн металлын биржийн зарласан тухайн сарын дундаж үнийг үндэслэн;

41.2.3.энэ хуулийн 41.2.1, 41.2.2-т зааснаас бусад экспортод гаргасан ашигт малтмалын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдох орлогыг уул уурхайн бүтээгдэхүүний дотоодын биржээс зарласан тухайн сарын дундаж үнийг үндэслэн;

41.2.4.экспортод гаргасан ашигт малтмалын үнийг энэ хуулийн 41.2.3-т заасны дагуу дотоодын биржээс зарлаагүй тохиолдолд олон улсын зах зээлийн тухайн сарын дундаж үнийг үндэслэн;

41.2.5.энэ хуулийн 41.2.1-т зааснаас бусад ашигт малтмалын дотоодод худалдсан, худалдахаар ачуулсан, өөрөө ашигласан ашигт малтмалын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдох орлогыг тусгай зөвшөөрөл эзэмшигчийн мэдүүлсэн тухайн ашигт малтмалын борлуулалтын гэрээний үнийг үндэслэн.

41.3.Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нь дараах төрөлтэй байна:

41.3.1.энэ хуулийн 41.4-т заасан хувиар ногдуулах ашигт малтмалын нөөц ашигласны суурь төлбөр;

41.3.2.энэ хуулийн 41.5-д заасан хувиар ногдуулах ашигт малтмалын нөөц ашигласны шатлан ногдуулах төлбөр;

41.3.3.энэ хуулийн 41.6-д заасан хувиар ногдуулах ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр;

41.3.4.энэ хуулийн 42 дугаар зүйлд заасан хувиар ногдуулах стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр.

41.4.Энэ хуулийн 41.2 дахь хэсгийн дагуу тооцсон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдох орлогын нийт дүнгээс дор дурдсан хүснэгтэд заасан дүнд хамаарах хэсэгт ашигт малтмалын нөөц ашигласны суурь төлбөрийг энэ хуулийн 41.6-д зааснаас бусад тохиолдолд 5 хувиар ногдуулна:

№	Бүтээгдэхүүний нэр төрөл	Хэмжих нэгж	Жишиж тооцох бүтээгдэхүүн	Ашигт малтмалын нөөц ашигласны суурь төлбөр ногдуулах нэгжийн үнэ /ам.доллар/
1	Зэс	тн	Зэс /цэвэр металлаар/	5000 хүртэл
2	Алт	унци	Алт /химийн цэврээр/	900 хүртэл
3	Боловсруулаагүй нүүрс	тн	Нүүрс	25 хүртэл
4	Цайр	тн	Цайр /цэвэр металлаар/	1500 хүртэл
5	Молибдени	тн	Молибдени	35000 хүртэл
6	Төмөр	тн	Төмрийн хүдэр	60 хүртэл
7	Гянтболд	тн	Гянтболдын исэл	25000 хүртэл
8	Хайлуур жонш	тн	Хайлуур жонш	100 хүртэл
9	Цагаан тугалга	тн	Цагаан тугалга /цэвэр металлаар/	17000 хүртэл
10	Хар тугалга	тн	Хар тугалга /цэвэр металлаар/	15000 хүртэл
11	Мөнгө	унци	Мөнгө /химийн цэврээр/	25 хүртэл
12	Магнезит	тн	Магнезитийн баяжмал	100 хүртэл
13	Хөнгөн цагаан	тн	Хөнгөн цагаан /цэвэр металлаар/	2300 хүртэл

14	Газрын ховор элемент	кг	Газрын ховор элементийн исэл	10 хүртэл
15	Фосфорит	тн	баяжмал	70 хүртэл
16	Цеолит	тн	Цеолит	200 хүртэл
17	Кварц	тн	Кварц	30 хүртэл
18	Чулуун давс	кг	Хүнсний давс	40 хүртэл
19	Хужир, шүү	тн	Хужир, шүү	140 хүртэл
20	Гөлтгөнө	тн	Гөлтгөнө	9 хүртэл
21	Уран	кг	Ураны исэл	70 хүртэл
22	Баяжуулсан нүүрс /Хуурай болон нойтон аргаар технологийн боловсруулалт хийсэн/	тн	Нүүрс	100 хүртэл
23	Эцсийн бүтээгдэхүүн /хагас кокс, кокс, хий, шингэн түлш, нүүрс-химийн бүтээгдэхүүн/	тн	Кокс	160 хүртэл
24	Бусад ашигт малтмал	тохирох нэгж	Хүдэр, баяжмал, эцсийн бүтээгдэхүүн	Олон улсын зах зээлийн тухайн сарын дундаж үнийг үндэслэн

**Тайлбар:**

*Жишээ 1. Зэсийн үнэ буюу ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдох орлогын нийт дүн 8500 ам.доллар байх тохиолдолд ашигт малтмалын нөөц ашигласны суурь төлбөрийг уг нийт дүнгийн 5000 ам.долларт нь 5 хувиар ногдуулах ба төлбөл зохих ашигт малтмалын нөөц ашигласны суурь төлбөрийн дүн нь 250 ам.доллар байна. Харин 5000 ам.доллараас давсан хэсэг болох 3500 ам.долларт энэ хуулийн 41.5-д заасан шатлан ногдуулах төлбөр тооцогдоно.*

*Жишээ 2. Зэсийн үнэ буюу ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдох орлогын нийт дүн 4000 ам.доллар байх тохиолдолд ашигт малтмалын нөөц ашигласны суурь төлбөрийг 4000 ам.долларын 5 хувиар ногдуулах ба төлбөл зохих ашигт малтмалын нөөц ашигласны суурь төлбөрийн дүн нь 200 ам.доллар байна. Энэ тохиолдолд 5000 ам.доллараас давсан хэсэг гэх утга байхгүй тул шатлан ногдуулах төлбөр тооцохгүй.*

41.5.Ашигт малтмалын нөөц ашигласны шатлан ногдуулах төлбөрийг энэ хуулийн 41.4-т заасан суурь төлбөр ногдуулах нэгж үнээс давсан үнээр тооцсон орлогод ашигт малтмалын боловсруулалтын түвшингээс хамаарч дараах хувиар ногдуулна:

№	Ашигт малтмалын нэр төрөл	Хэмжих нэгж	Жишиж үнэлэх бүтээгдэхүүн	Нэгж үнэ /ам.доллар/	Ашигт малтмалын боловсруулалтын түвшингээс хамаарч ногдуулах ашигт малтмалын нөөц ашигласны шатлан ногдуулах төлбөрийн хувь		
					Хүдэр	Баяжмал	Бүтээгдэхүүн
1	Зэс	тн	Зэс /цэвэр металлаар/	5001-6000	22.00	11.00	6.00
				6001-7000	24.00	12.00	7.00
				7001-8000	26.00	13.00	8.00
				8001-9000	28.00	14.00	9.00
				9001 ба түүнээс дээш	30.00	15.00	10.00
2	Алт	унци	Алт /химийн цэврээр/	901-1000	-	-	6.00
				1001-1100			7.00
				1101-1200			8.00
				1201-1300			9.00
				1301 ба түүнээс дээш			10.00
3	Цайр	тн	Цайр /цэвэр	1501-2000	6.00	5.80	5.40

			металлаар/	2001-2500	7.00	6.60	5.80
				2501-3000	8.00	7.40	6.20
				3001-3500	9.00	8.20	6.60
				3501 ба түүнээс дээш	10.00	9.00	7.00
4	Молибдени	тн	Молибдени	35001-40000	6.00	5.80	5.50
				40001-45000	7.00	6.60	6.00
				45001-50000	8.00	7.40	6.50
				50001-55000	9.00	8.20	7.00
				55001 ба түүнээс дээш	10.00	9.00	7.50
5	Төмөр	тн	Төмрийн хүдэр	61-70	6.00	5.70	5.40
				71-80	7.00	6.40	5.80
				81-90	8.00	7.10	6.20
				91-100	9.00	7.80	6.60
				101 ба түүнээс дээш	10.00	8.50	7.00
6	Гянтболд	тн	Гянтболдын баяжмал	25001-30000	6.00	5.80	-
				30001-35000	7.00	6.60	
				35001-40000	8.00	7.40	
				40001-45000	9.00	8.20	
				45001 ба түүнээс дээш	10.00	9.00	
7	Хайлуур жонш	тн	Хайлуур жоншны хүдэр, баяжмал	81-90	6.00	5.90	-
				91-100	7.00	6.80	
				101-110	8.00	7.70	
				111-120	9.00	8.60	
				121 ба түүнээс дээш	10.00	9.50	
8	Жоншны баяжмал (флотацийн баяжмал)	тн	Жоншны баяжмал /флотацийн баяжмал/	201-230	-	5.70	-
				231-260		6.40	
				261-290		7.10	
				291-320		7.80	
				321 ба түүнээс дээш		8.50	
9	Цагаан тугалга	тн	Цагаан тугалга /цэвэр металлаар/	17001-18000	6.00	5.80	5.50
				18001-19000	7.00	6.60	6.00
				19001-20000	8.00	7.40	6.50
				20001-21000	9.00	8.20	7.00
				21001 ба түүнээс дээш	10.00	9.00	7.50
10	Хар тугалга	тн	Хар тугалга /цэвэр металлаар/	1501-1800	6.00	5.80	5.40
				1801-2100	7.00	6.60	5.80
				2101-2400	8.00	7.40	6.20
				2401-2700	9.00	8.20	6.60
				2701 ба түүнээс дээш	10.00	9.00	7.00
11	Боловсруулаагүй нүүрс	тн	Нүүрс	26-50	6.00	-	-
				51-75	7.00		
				76-100	8.00		
				101-125	9.00		
				126 ба түүнээс дээш	10.00		
12	Баяжуулсан нүүрс (хуурай болон нойтон аргаар технологийн боловсруулалт хийсэн)	тн	Нүүрс	101-130	-	6.00	-
				131-160		6.50	
				161-190		7.00	

				191-210		7.50	
				211 ба түүнээс дээш		8.00	
13	Эцсийн бүтээгдэхүүн (хагас кокс, кокс, хий, шингэн түлш, нүүрс- химийн бүтээгдэхүүн)	тн	Кокс	161-190	-	-	5.50
				191-210			6.00
				211-240			6.50
				241-270			7.00
				271 ба түүнээс дээш			7.50
14	Мөнгө	унци	Мөнгө /химийн цэврээр/	26-30	-	-	6.00
				31-35			7.00
				36-40			8.00
				41-45			9.00
				46 ба түүнээс дээш			10.00
15	Магнезит	тн	Магнезитийн баяжмал	101-120	6.00	5.90	-
				121-140	7.00	6.80	
				141-160	8.00	7.70	
				161-180	9.00	8.60	
				181 ба түүнээс дээш	10.00	9.50	
16	Хөнгөн цагаан	тн	Хөнгөн цагаан /цэвэр металлаар/	2301-2600	6.00	5.90	5.50
				2601-2900	7.00	6.80	6.00
				2901-3200	8.00	7.70	6.50
				3201-3500	9.00	8.60	7.00
				3501 ба түүнээс дээш	10.00	9.50	7.50
17	Газрын ховор элемент	кг	Газрын ховор элементийн ислийн баяжмал	20-21	6.00	5.90	-
				21-30	7.00	6.80	
				31-40	8.00	7.70	
				41-50	9.00	8.60	
				51 ба түүнээс дээш	10.00	9.50	
18	Фосфорит	тн	баяжмал	71- 90	6.00	5.90	5.50
				91-110	7.00	6.80	6.00
				111-130	8.00	7.70	6.50
				131-150	9.00	8.60	7.00
				151 ба түүнээс дээш	10.00	9.50	7.50
19	Цеолит	тн	Цеолит	201-250	6.00	5.90	-
				251-300	7.00	6.80	
				301-350	8.00	7.70	
				351-400	9.00	8.60	
				401 ба түүнээс дээш	10.00	9.50	
20	Кварц	тн	Кварц	31-40	6.00	5.90	-
				41-50	7.00	6.80	
				51-60	8.00	7.70	
				61-70	9.00	8.60	
				71 ба түүнээс дээш	10.00	9.50	
21	Чулуун давс	кг	Хүнсний давс	41-50	6.00	5.90	-
				51-60	7.00	6.80	
				61-70	8.00	7.70	
				71-80	9.00	8.60	
				81 ба түүнээс дээш	10.00	9.50	

22	Хужир, шүү	тн	Хужир, шүү	141-150	6.00	5.90	-
				151-160	7.00	6.80	
				161-170	8.00	7.70	
				171-180	9.00	8.60	
				181 ба түүнээс дээш	10.00	9.50	
23	Гөлтгөнө	тн	Гөлтгөнө	10-11	6.00	-	-
				12-13	7.00		
				14-15	8.00		
				16-17	9.00		
				18 ба түүнээс дээш	10.00		
24	Уран	кг	Ураны исэл	71-100	-	6.00	-
				101-130		7.00	
				131-160		8.50	
				161-190		10.00	
				191-210		11.50	
				211-240		13.00	
				241-270		14.50	
				271-300		16.00	
				301 ба түүнээс дээш		17.50	

41.6.Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг дараах тохиолдолд дор дурдсан хувиар ногдуулах ба энэ хуулийн 41.4, 41.5-д заасан ашигт малтмалын нөөц ашигласны суурь болон шатлан ногдуулах төлбөр хамаарахгүй:

41.6.1.дотоодын цахилгаан болон дулааны станцад худалдсан, худалдахаар ачуулсан нүүрсэнд энэ хуулийн 41.2.5-д заасны дагуу тооцсон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдох орлогын нийт дүнгийн 2.5 хувиар;

41.6.2.дотоодод худалдсан, худалдахаар ачуулсан, өөрөө ашигласан түгээмэл тархацтай ашигт малтмалд энэ хуулийн 41.2.5-д заасны дагуу тооцсон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдох орлогын нийт дүнгийн 2.5 хувиар;

41.6.3.Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд худалдсан алтанд энэ хуулийн 41.2.1-д заасны дагуу тооцсон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдох орлогын нийт дүнгийн 5.0 хувиар.

41.7.Ашигт малтмалд агуулагдаж байгаа үндсэн болон эдийн засгийн ач холбогдол бүхий дагалдах ашигт малтмалын агуулга тус бүрт ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг энэ зүйлд заасан журмын дагуу тооцон ногдуулна.

41.8.Энэ хуулийн 41.7-д заасны дагуу ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах эдийн засгийн ач холбогдол бүхий дагалдах ашигт малтмалын жагсаалтыг холбогдох үндсэн ашигт малтмалын төрөл тус бүрээр геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.

41.9.Үндсэн ашигт малтмалын төрөл тус бүрийн тухайд дагалдах байдлаар агуулагдаж байгаа энэ хуулийн 41.8-д заасан жагсаалтад заагдаагүй эрдэс, химийн элементэд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулахгүй.

41.10.Ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон ашигт малтмал дамжуулан худалдсан этгээд ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, экспортолсон тухай бүр татварын хууль тогтоомжид заасан төлбөрийн баримт үйлдэх бөгөөд уг төлбөрийн баримтад ашигт малтмалын нэр төрөл, ангилал, тоо хэмжээ, борлуулалтын үнэ, ногдуулсан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн дүнг тусгасан байна.

41.11.Ашигт малтмалыг шууд, эсхүл ашигт агуулгыг нэмэгдүүлэн баяжмал, бүтээгдэхүүн үйлдвэрлэн экспортлоход ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг давхардуулж ногдуулахгүй бөгөөд тухайн ашигт малтмалын тухайд өмнө төлсөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг энэ хуулийн 41.10-т заасан төлбөрийн баримтад үндэслэн хасаж тооцно.

41.12.Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй этгээдээс ашигт малтмал худалдан авсан энэ хуулийн 41.1.3-т зааснаас бусад төлбөр төлөгч нь худалдан авсан ашигт малтмалд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг суутган авах бөгөөд 42.2, 42.3-т заасны дагуу тайлагнаж төсөвт төлнө.

41.13.Энэ хуулийн 41.5-д заасан хүдэр, баяжмал, бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинд тавигдах шаардлага, ангилал, тооцох зарчим, аргачлалыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.

41.14.Хайгуулын үйл ажиллагааны хүрээнд туршилтын журмаар олборлосон, хагас үйлдвэрлэлийн болон үйлдвэрлэлийн туршилтын зорилгоор олборлосон ашигт малтмалд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг энэ зүйлд заасны дагуу төлж тайлагнана.

41.15.Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу тогтворжуулах гэрчилгээ бүхий татвар төлөгчийн тухайд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тухайн гэрчилгээнд заасны дагуу холбогдох хувь, хэмжээгээр ногдуулна.

41.16.Дотоодод худалдсан, худалдахаар ачуулсан, өөрөө ашигласан ашигт малтмалын агуулга, шинж чанарыг Монгол Улсын итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний үр дүнд үндэслэн, экспортод гаргасан ашигт малтмалын хувьд гаалийн улсын байцаагчийн дүгнэлтэд үндэслэн тус тус тодорхойлно.

41.17.Дотоодод худалдсан, худалдахаар ачуулсан, өөрөө ашигласан, экспортод гаргасан ашигт малтмалд ногдох тухайн улирлын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг дараагийн улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор төсөвт төлнө.

41.18.Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банк нь худалдан авсан алтанд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг энэ хуулийн 41.2.1-д заасны дагуу тооцон төлбөл зохих ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг энэ хуулийн 41.6.3-т заасан хувиар ногдуулан суутган авч, улсын төсөвт шилжүүлнэ.

41.19.Энэ хуулийн 41.17-д заасны дагуу төсөвт төлсөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 10 хувийг тухайн уул уурхайн төсөл хэрэгжиж буй сумын, 20 хувийг аймгийн орон нутгийн хөгжлийн санд тус тус хуваарилна.



## **42 дугаар зүйл. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр**

42.1. Эрх бүхий байгууллагын зөвшөөрснөөр стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг гэрээний нөгөө талд шилжүүлэхээр талууд тохиролцсон тохиолдолд төрийн эзэмшлийн хувь, хэмжээг шилжүүлэн авч байгаа тал буюу ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийг энэ хуулийн 41.2-т заасны дагуу тооцоолсон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдох орлогын нийт дүнгээс тооцон улсын төсөвт төлнө.

42.2. Энэ хуулийн 42.1-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувийг Засгийн газар батална.

42.3. Энэ хуулийн 6.4, 6.5-т заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь нь тухайн ордын онцлогоос хамаарч 5 хувиас хэтрэхээргүй байна.

## **АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ**

### **43 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах үүрэг**

43.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашигт малтмал хайх, ашиглах, баяжуулах үйл ажиллагаанд байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон энэ хуульд заасан үүргийг биелүүлнэ.

### **44 дүгээр зүйл. Эрлийн ажлын үеийн байгаль орчин**

44.1. Геологийн судалгаа, эрлийн ажлын төсөвт тухайн талбайн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлыг тусгаж хэрэгжүүлнэ.

44.2. Эрлийн ажлын явцад газрын хэвлийг хөндөхгүй тохиолдолд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлыг байршуулахыг шаардахгүй.

### **45 дугаар зүйл. Хайгуулын үйл ажиллагааны байгаль орчин**

45.1. Хайгуулын үйл ажиллагааг эхлүүлэхээс өмнө энэ хуулийн 16.2.5-т заасан үнэлгээг, хайгуулын тусгай зөвшөөрлийн эхний гурван жилийн хугацаанд энэ хуулийн 18.3-д заасан үнэлгээг тус тус хийлгэнэ.

45.2. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын үйл ажиллагааг эхлүүлэхээс өмнө байгаль орчны төлөв байдлын үнэлгээг тухайн талбай байрших сум, дүүргийн Засаг дарга, геологи, уул уурхайн асуудал хариуцсан орон нутаг дахь нэгжид тус тус хүргүүлнэ.

45.3. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчны төлөв байдлын үнэлгээ болон байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээнд үндэслэж байгаль орчны менежментийн төлөвлөгөөг гурван жил тутамд боловсруулж, дараах журмаар хэрэгжилтийг нь жил бүр тайлагнана:

45.3.1.байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан тухайн жилийн нөхөн сэргээлтийн зардлыг энэ хуулийн 10.1.35-т заасны дагуу тухайн сум, дүүргийн тусгай дансанд байршуулах;

45.3.2.байгаль орчны менежментийн төлөвлөгөөг тухайн сум, дүүргийн байгаль орчны хяналтын улсын байцаагчид хүргүүлэх;

45.3.3.байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг сум, дүүргийн Засаг даргад хүргүүлэх;

45.3.4.байгаль орчны менежментийн төлөвлөгөө, биелэлтийн тайлан олон нийтэд нээлттэй байна.

45.4.Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөг бүрэн биелүүлсэн бол энэ хуулийн 45.4.1-д заасны дагуу байршуулсан мөнгөн хөрөнгийг сум, дүүргийн Засаг дарга тусгай зөвшөөрөл эзэмшигчид буцаан олгоно.

45.5.Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөг бүрэн биелүүлээгүй бол сум, дүүргийн Засаг дарга нь энэ хуулийн 45.3.1-д заасан хөрөнгөөр байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг мэргэжлийн этгээдээр гүйцэтгүүлэх бөгөөд нэмж шаардагдах зардлыг хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчээс гаргуулна.

45.6.Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд энэ хуулийн 45.3-т заасан нөхцөл, журмыг баримтална.

45.7.Энэ хуулийн 45.3.1-д заасан зардлыг байршуулах, хүлээн авах, буцаан олгох, зарцуулах журмыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

45.8.Энэ хуулийн 45.3.3-т заасан биелэлтийн тайланг хүлээн авснаас хойш ажлын 15 өдрийн дотор тухайн сум, дүүргийн байгаль орчны хяналтын улсын байцаагч нь биелэлтийн тайлантай танилцаж, саналаа сум, дүүргийн Засаг даргад болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчид хүргүүлнэ.

## **46 дугаар зүйл.Ашиглалт, баяжуулалтын үйл ажиллагааны байгаль орчин**

46.1.Ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргахаас өмнө байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг батлуулсан байна.

46.2.Энэ хуулийн 46.1-д заасан баримт бичиг болон ашиглалт, баяжуулалтын үйл ажиллагааны төлөвлөгөөнд үндэслэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг жил бүр боловсруулж, хэрэгжилтийг дараах журмаар хангана:

46.2.1.байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулах;

46.2.2.батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хувийг тухайн сум, дүүргийн Засаг даргад, геологи, уул уурхайн асуудал хариуцсан орон нутаг дахь нэгжид тус тус хүргүүлж, үлдэх хувийг тусгай зөвшөөрөл эзэмшигч хадгалах.

46.3.Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд энэ хуулийн 46.2-т заасан нөхцөл, журмыг баримтална.

46.4.Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг ашиглалт, баяжуулалтын үйл ажиллагааны улмаас тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа иргэдэд танилцуулна.

46.5.Энэ хуулийн 46.2.1, 46.3-т заасан төлөвлөгөөг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүлээн авснаас хойш ажлын 15 өдрийн дотор багтаан хянан баталж, ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид хүргүүлнэ.

46.6.Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, биелэлтийн тайлан олон нийтэд нээлттэй байна.

## **АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ ОРОН НУТГИЙН ХАРИЛЦАА**

### **47 дугаар зүйл.Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх эрлийн ажлын үед орон нутагтай харилцах**

47.1.Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх эрлийн ажлын үед орон нутагтай хамтран ажиллах гэрээ байгуулах шаардлагагүй.

47.2.Сум, дүүргийн Засаг дарга нь улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх эрлийн ажлын талаар тухайн сум, дүүргийн иргэд, дээд шатны Засаг даргад мэдээлнэ.

### **48 дугаар зүйл.Ашиглалт, баяжуулалтын үйл ажиллагааны үед орон нутагтай харилцах**

48.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив, тусламж өгөх асуудлаар орон нутагтай хамтран ажиллах гэрээг сум, дүүргийн Засаг даргатай байгуулж, аймаг, нийслэлийн Засаг дарга баталгаажуулна.

48.2.Нутгийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан энэ хуулийн 48.1-д заасан гэрээг олон нийтэд нээлттэй, ил тод байлгана.

48.3.Нутгийн захиргааны болон бусад байгууллага, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээд энэ хуулийн 48.1-д заасан гэрээнд тусгагдаагүй хандив, тусламжийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс шаардахыг хориглоно.

### **49 дүгээр зүйл.Олон нийтийн оролцоо**

49.1.Тухайн орон нутагт хийгдэж байгаа хайгуул, ашиглалт, баяжуулалтын үйл ажиллагаа, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, хууль тогтоомжид заасан журмын дагуу мэдээлэл олон нийтэд нээлттэй байна.

49.2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн орон нутагтай хамтран ажиллах гэрээ, байгаль орчны нөлөөллийн

үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих ажиллагаанд олон нийтийн оролцоог хангаж ажиллана.

49.3.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нь тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа иргэдэд ашигт малтмал, геологи, уул уурхайн салбарын талаар мэдээллийг хүргэх, сурталчлах ажлыг тогтмол зохион байгуулна.

## **50 дугаар зүйл.Байгаль орчин, нийгэм, засаглалын тайлан**

50.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн үйл ажиллагааг иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй байдлыг хангах зорилгоор байгаль орчин, нийгэм, засаглалын тайланг гурван жил тутамд гаргана.

50.2.Энэ хуулийн 50.1-д заасан тайлангийн үнэн зөв байдлыг тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигч хариуцна.

50.3.Энэ хуулийн 50.1-д заасан тайлан нь тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн энэ хуульд заасан байгаль орчны талаар хүлээх үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

## **АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ, ТЕХНОЛОГИЙН АУДИТ**

### **51 дүгээр зүйл.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий шаардлага**

51.1.Ашигт малтмалыг эрэх, хайх, ашиглах, баяжуулах үйл ажиллагааны ажлын байран дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангахтай холбоотой харилцаанд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг баримтална.

51.2.Ашигт малтмалыг эрэх, хайх, ашиглах, баяжуулах үйл ажиллагаанд оролцогч талууд энэ хуулийн 10.1.8, 10.1.9, 10.1.10, 10.1.11, 10.1.12-т заасан хөдөлмөрийн аюулгүй байдлын дүрмийг баримтлан аюулгүй байдлыг хангаж ажиллах үүрэгтэй.

51.3.Ажил хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 17.2-т зааснаас гадна дараах төрлөөр зохион байгуулж болно:

51.3.1.аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, нийт ажилтны сургалт;

51.3.2.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтныг мэргэшүүлэх сургалт;

51.3.3.ажлын талбайд зорчих болон гэрээт гүйцэтгэгчийн аюулгүй байдлыг хангах сургалт.

51.4.Энэ хуулийн 51.3-т заасан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг тусгай зөвшөөрөл эзэмшигчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээд баталж, хэрэгжилтэд хяналт тавина.

## **52 дугаар зүйл. Технологийн аудит**

52.1. Технологийн аудитыг дараах тохиолдолд заавал хийлгэнэ:

52.1.1. ашиглах, баяжуулах технологи өөрчлөгдөх;

52.1.2. ашиглах, баяжуулах технологийн горимын хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгөх зорилгоор ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага шаардсан;

52.1.3. ашиглах, баяжуулах үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөний улмаас үйлдвэрлэлийн осол гарсан;

52.1.4. баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч үйл ажиллагаа эхлүүлэхээс өмнө.

52.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь техник, технологийн ашиглалтыг сайжруулах, зардлыг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах зорилгоор технологийн аудит хийлгэж болно.

52.3. Ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь технологийн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлнэ.

52.4. Ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь технологийн аудитын зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг тухайн жилийн ашиглалтын эсхүл баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны тайланд хавсаргаж ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

52.5. Технологийн аудитыг 10.1.17-д заасан журмын дагуу Уул уурхайн судалгаа, хөгжлийн төвийн ерөнхий инженерээр ахлуулсан эрх олгогдсон аудиторын баг гүйцэтгэнэ.

52.6. Технологийн аудиторын эрх олгох, сунгах, түдгэлзүүлэх, цуцлах журам, технологийн аудит хийх аргачлалыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

52.7. Төрийн аудитын байгууллагаас захиргааны байгууллагын үйл ажиллагаанд аудит хийхтэй холбогдсон харилцаанд энэ зүйл хамаарахгүй.

### **АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ТӨЛӨВЛӨГӨӨ, ТАЙЛАН МЭДЭЭ**

## **53 дугаар зүйл. Төлөвлөгөө, тайлангийн нийтлэг зохицуулалт**

53.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь геологийн судалгаа, эрэл, хайгуул, ашиглалтын болон баяжуулалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг батлагдсан маягт, зааврын дагуу үнэн зөв гаргана.

53.2. Геологийн судалгаа, эрлийн ажлын тайлан, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хайгуул, ашиглалт, баяжуулалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлангийн хууль тогтоомжид заасан журмын дагуу нууцад хамааруулснаас бусад мэдээлэл олон нийтэд нээлттэй байна.

53.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 48.1-д заасан орон нутагтай

хамтран ажиллах гэрээний тухайн жилийн хэрэгжилтийг дараа оны 1 дүгээр улиралд багтаан олон нийтэд нээлттэй мэдээлнэ.

#### **54 дүгээр зүйл.Геологийн судалгаа, эрлийн ажлын тайлан**

54.1.Геологийн судалгаа, эрлийн ажлын жилийн тайланг төсөл тус бүрээр дараа оны 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор геологи, судалгааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

54.2.Тусгай зөвшөөрлийн эзэмшигч нь өөрийн талбайд гүйцэтгэсэн геологийн судалгаа, эрлийн ажлын жилийн тайланг энэ хуулийн 55.1.2-т заасан хугацаанд ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

#### **55 дугаар зүйл.Хайгуулын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан**

55.1.Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад дор дурдсан хугацаанд хүргүүлнэ:

55.1.1.хайгуулын эхний гурван жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг тусгай зөвшөөрөл олгогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор, дараагийн гурван жилийн төлөвлөгөөг өмнөх гурван жилийн сүүлийн жилийн 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор;

55.1.2.хайгуулын ажлын жилийн тайланг дараа оны 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор.

55.2.Ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 10.1.26-д заасан шаардлага хангасан төлөвлөгөө, тайланг хүлээн авснаас хойш 90 хоногийн дотор хянан баталгаажуулна.

#### **56 дугаар зүйл.Ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан**

56.1.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад дор дурдсан хугацаанд хүргүүлнэ:

56.1.1.ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөг баталгаажсан нөөцөд тулгуурлан жил бүрийн 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор;

56.1.2.ашиглалтын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг дараа оны 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор.

56.2.Ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 10.1.26-д заасан шаардлага хангасан төлөвлөгөө, тайланг хүлээн авснаас хойш 90 хоногийн дотор хянан баталгаажуулна.

56.3.Энэ хуулийн 56.1.2-т заасан тайланг хуульд заасан хугацаанд ирүүлж баталгаажуулсан нь дараа жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг баталгаажуулах үндэслэл болно.

#### **57 дугаар зүйл.Баяжуулалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан**

57.1.Баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах төлөвлөгөө, тайланг дор дурдсан хугацаанд ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ:

57.1.1.баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг өмнөх оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор;

57.1.2.баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны тайланг дараа оны 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор.

57.2. Ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 10.1.26-д заасан шаардлага хангасан төлөвлөгөө, тайланг хүлээн авснаас хойш 90 хоногийн дотор хянан баталгаажуулна.

## **58 дугаар зүйл.Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайлан**

58.1.Энэ хуулийн 41.17-д заасан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн нийт хэмжээг ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан маягтын дагуу улирал тутам өссөн дүнгээр гаргаж, тус улирлын тайланг дараагийн улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны өдрийн дотор тус тус ирүүлнэ.

58.2.Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банк нь энэ хуулийн 41.18-д заасны дагуу төсөвт шилжүүлсэн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайлан, мэдээг геологи, уул уурхайн эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан маягтын дагуу дараа сарын 20-ны өдрийн дотор тус байгууллагад хүргүүлнэ.

## **АРВАН ТАВДУГААР БҮЛЭГ ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН САЛБАР ДАХЬ ТӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТ**

### **59 дүгээр зүйл.Улсын Их Хурлын бүрэн эрх**

59.1.Ашигт малтмалын асуудлаар Улсын Их Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

59.1.1.геологи, уул уурхайн салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох;

59.1.2.ашигт малтмалын эрэл, хайгуул, ашиглалт, баяжуулалтын үйл ажиллагаатай холбогдсон хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар Засгийн газраас зохион байгуулж байгаа ажилд хяналт тавих;

59.1.3.улсын тусгай хамгаалалттай газарт ашигт малтмал эрэх, хайх, ашиглах асуудлыг шийдвэрлэх;

59.1.4.Засгийн газраас өргөн мэдүүлснээр, эсхүл өөрийн санаачлагаар тухайн ашигт малтмалын ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах, хасах;

59.1.5.Засгийн газрын өргөн мэдүүлснээр, эсхүл өөрийн санаачлагаар стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь,

хэмжээг улсын нөөцийн нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн эрдэс баялгийн хэмжээ, энэ хуулийн 6.4, 6.5-д заасан хэмжээг харгалзан тогтоох;

59.1.6.хууль тогтоомжид заасан бусад.

## **60 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх**

60.1.Ашигт малтмалын асуудлаар Засгийн газар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

60.1.1.ашигт малтмал эрэл, хайгуул, ашиглалт, баяжуулалтын үйл ажиллагаатай холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;

60.1.2.геологи, уул уурхайн салбарыг хөгжүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэх;

60.1.3.чухал ашигт малтмалын жагсаалт батлах;

60.1.4.хайгуулын тусгай зөвшөөрлийг өргөдлөөр болон сонгон шалгаруулалтаар олгох талбайн солбицол батлах;

60.1.5.улсын тусгай хамгаалалттайгаас бусад тусгай хэрэгцээний газарт ашигт малтмал эрэх, хайх, ашиглах эрх олгох;

60.1.6.орон нутагтай хамтран ажиллах гэрээ байгуулах журам батлах;

60.1.7.энэ хуулийн 3.3-т заасан төсөл, хөтөлбөрийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг ашиглах талбайн солбицол батлах;

60.1.8.энэ хуулийн 3.3-т заасан төсөл, хөтөлбөрийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг ашиглах тусгай журмыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санал болгосноор батлах;

60.1.9.тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах, хасах саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

60.1.10.стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг тогтоох тухай саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

60.1.11.стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашиглах гэрээ байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих журам батлах;

60.1.12.стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашиглахад төрөөс оруулах хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх;

60.1.13.төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээр дамжуулан ашигт малтмал эрэх, хайх, ашиглах, баяжуулах тодорхой үйл ажиллагаанд оролцох;

60.1.14.геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн хайгуулын болон энэ хуулийн 24.1-т зааснаас бусад тохиолдолд ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох талбайг солбицлоор тогтоож, нийтэд мэдээлэх;



57.1.15.стратегийн ач холбогдол бүхий ордын талбайн хил заагийг тогтоох;

57.1.15.хууль тогтоомжид заасан бусад.

## **58 дугаар зүйл.Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**

58.1.Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

58.1.1.геологи, уул уурхайн салбарын талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрийг боловсруулах, биелэлтийг хангах;

58.1.2.ашигт малтмалын тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газраас гаргасан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

58.1.3.уурхай, үйлдвэрийн хаалтын үйл ажиллагаанд хяналт тавих;

58.1.4.геологи, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх;

58.1.5.харьяа байгууллагынхаа үйл ажиллагаанд хяналт тавих;

58.1.6.геологийн судалгааны ажлын талбай, төлөвлөгөө, төсөл, төсвийг тодорхойлох, тодотгох, үр дүнгийн тайланг хүлээн авсан тухай шийдвэр гаргах;

58.1.7.хууль тогтоомжид заасан дүрэм, журам, заавар, маягт, аргачлалыг батлах;

58.1.8.стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашиглах үйл ажиллагаанд хяналт тавих;

58.1.9.хайгуул, ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн стратегийн зорилт, хөгжлийн төлөвлөгөөг батлах, үйл ажиллагаанд хяналт тавих;

58.1.10.энэ хуулийн 59.1.9-д заасан хуулийн этгээдийн шийдвэр, үйл ажиллагааг салбарын бодлоготой уялдуулах арга хэмжээг авах;

58.1.11.Ашигт малтмалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт болон ашигт малтмал эрэх, хайх, ашиглах, баяжуулах үйл ажиллагаанд тавих улсын хяналтыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага гүйцэтгэх;

58.1.12.хайгуулын ажлын үр дүнгийн тайлан-техник эдийн засгийн үндэслэл, техникийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл олгох;

58.1.13.энэ хуульд заасан бусад.

## **59 дүгээр зүйл.Геологи, судалгааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг**

59.1.Геологийн судалгааны талаарх төрийн бодлогыг Газрын хэвлийн тухай хууль, энэ хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлнэ.

59.2.Геологи, судалгааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

59.2.1.Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр геологийн зураглал, эрлийн ажил гүйцэтгэж, ашигт малтмалын тархалтын зүй тогтол, минерагений судалгаа, үнэлгээний ажил хийж эрдэс баялаг, ашигт малтмалын хэтийн төлөвийг тодорхойлох;

59.2.2.улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын талбай сонгох, геологийн даалгавар боловсруулах, төлөвлөгөө, төсөл, төсвийг тодорхойлох, тодотгох, ажлын явц, хэрэгжилт, гүйцэтгэлд хяналт тавих, зөвлөмж өгөх, үр дүнгийн тайланг хянах, үр дүнгийн тайланг хүлээн авсан тухай шийдвэрийг бүртгэх;

59.2.3.үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн сан бүрдүүлэх, түүнийг баяжуулах, боловсруулах, нууцын зэрэглэлд хамааруулснаас бусад мэдээллээр сонирхсон этгээдэд үйлчилгээ үзүүлэх;

59.2.4.ашигт малтмалын нөөц, түүний хөдөлгөөнийг улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэх, тэнцэл хөтлөх;

59.2.5.энэ хуулийн 11, 12, 13 дугаар зүйлд заасан үйл ажиллагааны хэрэгжилт, гүйцэтгэлд хяналт тавих;

59.2.6.улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдсэн геологийн суурь судалгааны мэдээлэл, эрдэс баялаг, ашигт малтмалын хэтийн төлөвт үндэслэн улсын төсвийн хөрөнгөөр явуулах эрлийн үйл ажиллагаа явуулах талбайн солбицлыг жил бүр тодорхойлох;

59.2.7.энэ хуулийн 59.2.6-д заасан геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан эрлийн үйл ажиллагааны сонгон шалгаруулалтыг зарлаж, шалгарсан этгээдтэй гэрээ байгуулах;

59.2.8.ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын болон өргөдлийн талбайн геологийн суурь судалгааны мэдээллийг бэлтгэх, талбайг нарийвчлах;

59.2.9.геологийн баримтын төв архив буюу төрийн төрөлжсөн архивыг хамаарч, түүний мэдээлэл бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалтыг хариуцах;

59.2.10.эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургууль шинжлэх ухаан, танин мэдэхүй, сургалтын зорилгоор тойм судалгааг гүйцэтгүүлэх, энэ тухай бүртгэх;

59.2.11.гадаад, дотоодын ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай хамтран ажиллах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, сургалт зохион байгуулах, салбарын үйл ажиллагааг сурталчлах;

59.2.12.Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологийн судалгааны ажил, хувийн хөрөнгөөр гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайлан-техник, эдийн засгийн үндэслэл, анхдагч материалыг хүлээн авахаар гаргасан шийдвэрийг үндэслэн архивт хүлээн авч, мэдээллийн санд оруулах;

59.2.13.геологи, уул уурхайн салбартай холбогдолтой төрөл бүрийн эрдэм шинжилгээний ажлын үр дүн, бүтээл, ном товхимол хүлээн авч мэдээллийн санд оруулах;

59.2.14.улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологийн бүх төрлийн ажлын зардлын нөхөн төлбөрийг тооцоолох;

59.2.15.энэ хуульд заасан бусад.

## **60 дугаар зүйл.Ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг**

60.1.Ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь ашигт малтмалын талаарх төрийн бодлогыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ.

60.2.Ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

60.2.1.хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн зураг зүйн бүртгэл хөтлөх;

60.2.2.хайгуул, ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох, цуцлах, нөхөн олгох;

60.2.3.хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийг шилжүүлэх, барьцаалах, олгогдсон талбайг хэсэгчлэн болон бүхэлд нь буцаан өгөх ажиллагааг бүртгэх;

60.2.4.тусгай зөвшөөрлийн төлбөр төлөлтийн бүртгэл хөтлөх, үйлчилгээний хөлс хураан авах;

60.2.5.хайгуулын ажилд зарцуулсан зардлын хэмжээг тусгай зөвшөөрөл эзэмшигчийн геологи, хайгуулын ажлын жилийн тайлан болон санхүүгийн тайлан тэнцэлд тулгуурлан баталгаажуулах;

60.2.6.хайгуулын ажилд зарцуулсан зардлын хэмжээг шаардлагатай тохиолдолд газар дээр нь шалгах;

60.2.7.тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд үүссэн тусгай зөвшөөрлийн талбайн хилийн маргааныг шийдвэрлэх;

60.2.8.энэ хуулийн 57.1.4, 57.1.7-д заасан талбайн солбицлыг орон нутагт мэдэгдэх;

60.2.9.сонгон шалгаруулалтаар олгох хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайг бэлтгэх;

60.2.10.хууль тогтоомжийн хүрээнд тусгай зөвшөөрлийн болон түүний зураг зүйн бүртгэл, мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгах;

60.2.11.хууль тогтоомжийн хүрээнд заасан мэдээллийн санг бүрдүүлэх, түүнийг баяжуулах;

60.2.12.уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн үнийг судалж, хэтийн төлөвийг тодорхойлох;

60.2.13.ордын нөөцийн хөдөлгөөний бүртгэл хөтлөх;

60.2.14.хайгуулын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг хянах, хүлээн авах;

60.2.15.хайгуул, ашиглалт, баяжуулалтын үйл ажиллагаатай газар дээр нь шалгах, хэрэгжилттэй танилцах;

60.2.16.энэ хуулийн 59.2.14-т заасныг үндэслэн улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологи, хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөрийн гэрээ байгуулах;

60.2.17.ашиглалт, баяжуулалтын үйл ажиллагааны жил бүрийн төлөвлөгөө, тайланг хүлээн авч, хянан баталгаажуулах;

60.2.18.энэ хуулийн 46.1-д заасан орон нутагтай хамтран ажиллах гэрээний тухайн жилийн хэрэгжилтийн тайланг хүлээн авах, холбогдох мэдээллээр төрөлжүүлсэн сан үүсгэх;

60.2.19.энэ хуульд заасан бусад.

## **61 дүгээр зүйл.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын эрх хэмжээ**

61.1.Ашигт малтмалын асуудлаар аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах эрх хэмжээг хэрэгжүүлнэ:

61.1.1.ашигт малтмалын хууль тогтоомж, Засгийн газраас гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулахад нутгийн захиргааны байгууллагыг удирдлагаар хангах;

61.1.2.геологи, уул уурхайн асуудал хариуцсан орон нутаг дахь нэгжийн үйл ажиллагааг дэмжиж, хамтран ажиллах;

61.2.Ашигт малтмалын асуудлаар сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах эрх хэмжээг хэрэгжүүлнэ:

61.2.1.ашигт малтмалын хууль тогтоомж, Засгийн газраас гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулахад нутгийн захиргааны байгууллагыг удирдлагаар хангах;

61.2.2.геологи, уул уурхайн асуудал хариуцсан орон нутаг дахь нэгжийн үйл ажиллагааг дэмжиж, хамтран ажиллах.

61.2.3.Энэ хуулийн 9.5-д заасан төлбөрийг тухайн сум, дүүргийн төсөвт төвлөрүүлж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих болон боловсрол, эрүүл мэндийн салбарт зарцуулах бөгөөд энэ талаарх журмыг батлах.

## **62 дугаар зүйл.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын эрх хэмжээ**

62.1.Ашигт малтмалын асуудлаар аймаг, нийслэлийн Засаг дарга дараах эрх хэмжээг хэрэгжүүлнэ:

62.1.1.ашигт малтмалын хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан эрх бүхий байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг харьяа нутаг дэвсгэртээ зохион байгуулах, биелэлтийг тайлагнах, олон нийтэд мэдээлэх;

62.1.2.энэ хуулийн 46.1-д заасан орон нутагтай хамтран ажиллах гэрээг баталгаажуулах, зарцуулалтыг нээлттэй тайлагнах;

62.1.3.энэ хуулийн 47.1-д заасан орон нутагтай хамтран ажиллах гэрээ, биелэлтийн тайланг ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;

62.1.4.энэ хуулийн 57.1.4, 57.1.7-д заасан солбицлыг тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа иргэдэд танилцуулах ажлыг зохион байгуулах.

62.2.Ашигт малтмалын асуудлаар сум, дүүргийн Засаг дарга дараах эрх хэмжээг хэрэгжүүлнэ:

62.2.1.Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчээс ирүүлсэн хайгуулын үйл ажиллагааны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа иргэдэд танилцуулах;

62.2.2.тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй орон нутагтай хамтран ажиллах гэрээ байгуулах, хэрэгжилтийг хангах, зарцуулалтыг нээлттэй тайлагнах;

62.2.3.геодези-маркшейдерийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдийг сонгож, байнгын шав тэмдгийг байрлуулсан тухай актыг хүлээж авч, салбарын хяналтын байгууллага болон ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад өгөх;

62.2.4.уурхай, баяжуулах үйлдвэрийг байнгын ашиглалтад хүлээн авах комиссын болон хаалтын техникийн комиссын бүрэлдэхүүнд төлөөлөл томилон оролцуулах;

## **63 дугаар зүйл.Геологи, уул уурхайн асуудал хариуцсан орон нутаг дахь нэгж**

63.1.Орон нутагт геологи, уул уурхайн салбарын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, сурталчлан таниулах, хөрөнгө оруулагч, тусгай зөвшөөрөл эзэмшигч, иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх, төрийн болон нутгийн захиргааны байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог хангах чиг үүргийг геологи, уул уурхайн асуудал хариуцсан орон нутаг дахь нэгж хэрэгжүүлнэ.

63.2.Геологи, уул уурхайн асуудал хариуцсан орон нутаг дахь нэгж нь ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын бүтцэд харъяалагдана.

#### **64 дүгээр зүйл.Геологи, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтыг дэмжих зөвлөл**

64.1.Геологи, уул уурхайн салбарын хөгжлийг дэмжих, салбарын татвар, хөрөнгө оруулалтын орчин, өрсөлдөх чадварыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих орон тооны бус зөвлөлийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд байгуулж болно.

64.2.Энэ хуулийн 64.1-д заасан зөвлөл нь төрийн болон хөрөнгө оруулагчдын төлөөллөөс бүрдсэн 9 хүртэлх гишүүнтэй байна.

64.3.Хөрөнгө оруулалтыг дэмжих зөвлөлийн үйл ажиллагааны хуулиар нууцад хамааруулснаас бусад мэдээлэл олон нийтэд ил тод байна.

#### **65 дугаар зүйл.Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл**

65.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт хийгдсэн геологийн судалгааны ажлын үр дүнгийн тайлан, хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, ашигт малтмал ашиглах болон баяжуулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөлд дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл ажиллана.

65.2.Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл нь дараах дэд зөвлөлтэй байна:

65.2.1.геологийн суурь судалгаа, эрлийн ажлын үр дүнгийн тайланг хэлэлцэх дэд зөвлөл;

65.2.2.хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, ашиглалт, баяжуулалтын техник, эдийн засгийн үндэслэл, техникийн зураг төсөл хэлэлцэх дэд зөвлөл.

65.3.Энэ хуулийн 65.2-т заасан дэд зөвлөл дараах бүрэлдэхүүнтэй байна:

65.3.1.геологийн суурь судалгаа, эрлийн ажлын үр дүнгийн тайланг хэлэлцэх дэд зөвлөл нь геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, геологи, судалгааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, салбарын эрдэм шинжилгээ, судалгаа, сургалтын байгууллагын болон бусад төлөөлөл;

65.3.2.хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, ашиглалт, баяжуулалтын техник, эдийн засгийн үндэслэл, техникийн зураг төслийг хэлэлцэх дэд зөвлөл нь геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, уул уурхайн судалгаа, хөгжлийн төв, төрийн өмчит лаборатори, сургалтын байгууллагын болон бусад төлөөлөл.

65.4.Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн гишүүдэд тавигдах мэргэжил, ур чадвар, туршлагын болон бусад шаардлагыг энэ хуулийн 10.1.20-д заасан журмаар зохицуулна.

65.5.Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 66.2-т заасан дэд зөвлөлийн даргыг томилно.

65.6.Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл нь хайгуулын ажлын үр дүнгийн тайлан-техник, эдийн засгийн үндэслэл, техникийн зураг төсөлд дүгнэлт, шүүмж гаргах мэргэшсэн шинжээчийг энэ хуулийн 66.2.3-т заасан Уул уурхайн судалгаа, хөгжлийн төв, энэ хуулийн 10.1.6-д заасан журмын дагуу эрх олгогдсон зөвлөх болон мэргэшсэн мэргэжилтний хамтарсан баг томилон ажиллуулна.

65.7.Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааны мэдээлэл, мэргэшсэн шинжээчдийн мэдээлэл олон нийтэд нээлттэй байна.

## **66 дугаар зүйл.Уул уурхайн судалгаа, хөгжлийн төв**

66.1.Уул уурхайн судалгаа, хөгжлийн төв нь уул уурхайн тогтвортой хөгжлийн талаарх төрийн бодлого, стратеги, техник, технологи, инновацын хөгжил, ус, эрчим хүчний хэмнэлт, түүнчлэн геологи, уул уурхайн салбарын үр өгөөж, бүтээмжийг нэмэгдүүлэх, олон улсад өрсөлдөх чадварыг сайжруулахад чиглэсэн цогц судалгаа, дүн шинжилгээ хийх, санал зөвлөмж боловсруулах стратегийн зорилтыг хэрэгжүүлэхэд геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажиллана.

66.2.Уул уурхайн судалгаа, хөгжлийн төв нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

66.2.1.салбарын бодлогын суурь судалгаа, олон улсын болон дотоодын зах зээлийн хэтийн төлөв, хөрөнгө оруулалт, татварын орчны судалгаа, төсөл, хөтөлбөрийн хөгжүүлэлт, дэд бүтцийн судалгаа хийх, үнэлэлт дүгнэлт өгөх;

66.2.2.хөдөлмөрийн аюулгүй байдал, техник ашиглалт, аюулгүй байдал, эрүүл ахуйн хэм хэмжээний холбогдолтой олон улсын болон дотоодын эрх зүйн актуудын хэрэгжилтийн статистик судалгаанд тулгуурлан салбарын дүрэм, стандарт, норм нормчлолын бичиг баримт боловсруулах, геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулах;

66.2.3.хайгуулын ажлын үр дүнгийн тайлан-техник, эдийн засгийн үндэслэл, техникийн зураг төсөлд мэргэжлийн байгууллагыг төлөөлж геологи, судалгааны асуудал хариуцсан болон ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын архив, сан хөмрөг, мэдээллийн сангийн мэдээллийн нийцэл, холбогдох харилцааг зохицуулсан хэм хэмжээний актууд болон хууль эрх зүйн актуудын шаардлагыг хангасан байдалд дүгнэлт гаргах шинжээчээр ажиллах, өөрийн гаргасан дүгнэлтэндээ хариуцлага хүлээх;

66.2.4.техник, технологийн түвшний үнэлгээ хийх, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын захиалгаар төслийн хэрэгжилтэд энэ хуулийн 50 дугаар зүйлд заасан технологийн аудитын чиг үүргийг хэрэгжүүлэх;

66.2.5.уул уурхайн салбарын мэргэжилтэй боловсон хүчний судалгаа, мэргэжлийн боловсрол дээшлүүлэх, тэсэлгээчин, аврагч, технологийн аудитор, хөдөлмөрийн аюулгүй байдлын зэрэг тусгай чиг үүрэг бүхий үйл ажиллагаа эрхлэх мэргэжилтэн бэлтгэх, зөвлөх болон мэргэшсэн зэрэг олгох, мэргэшүүлэх сургалтыг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран гэрээний үндсэн дээр зохион байгуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;

66.2.6.технологийн аудит хийх байгууллагад энэ хуулийн 10.1.17-д заасан журмын дагуу, маркшейдерын ажил, үйлчилгээ эрхлэх байгууллагад энэ хуулийн 10.1.18-д заасан журмын дагуу, хайгуулын ажлын үр дүнгийн тайлан-техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах байгууллагад энэ хуулийн 10.1.38-д заасан журмын дагуу тус тус эрх олгох, сунгах, цуцлах талаарх саналыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргаж шийдвэрлүүлэх;

66.2.7.тусгай зөвшөөрлийн хилийн маргаан, шүүхийн болон цагдаагийн байгууллагаас гаргасан хүсэлтийг үндэслэн төрийг төлөөлөн шинжээчээр ажиллах, маркшейдерын хэмжилт хийх, мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргах ба өөрийн гаргасан дүгнэлтэд хариуцлага хүлээх;

66.2.8.хайгуулын ажлын үр дүнгийн тайлан-техник, эдийн засгийн үндэслэл, техникийн зураг төсөлд хийсэн зохиогчийн хяналтын гэрээт ажилд экспертын баталгаажуулалт хийх.

66.3.Уул уурхайн судалгаа, хөгжлийн төвийн ерөнхий судлаач нь энэ зүйлийн 66.2.1, 66.2.2, 66.2.3, ерөнхий инженер нь энэ зүйлийн 66.2.4, 66.2.5, 66.2.6, 66.2.7, 66.2.8-д заасан асуудлыг хариуцна.

66.4.Уул уурхайн судалгаа, хөгжлийн төвийн санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

66.4.1.захиалгат суурь болон статистик судалгааны ажлын төлбөр;

66.4.2.салбарын дүрэм, норм нормчлолын бичиг баримт борлуулсны орлого;

66.3.3.хайгуулын ажлын үр дүнгийн тайлан-техник, эдийн засгийн үндэслэлд гаргасан шинжээчийн дүгнэлтийн үйлчилгээний хураамж;

66.3.4.төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын захиалгаар хийсэн технологийн аудитын ажлын төлбөр;

66.3.5.уул уурхайн салбарын мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, зөвлөх болон мэргэшсэн зэрэг олгох, мэргэшүүлэх сургалтын төлбөр;

66.3.6.технологийн аудит, маркшейдерын ажил, үйлчилгээ, хайгуулын ажлын үр дүнгийн тайлан-техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах эрх олгох, сунгахтай холбоотой үйлчилгээний хураамж;

66.3.7.тусгай зөвшөөрлийн хилийн маргаан, шүүхийн болон цагдаагийн байгууллагаас гаргасан хүсэлтийг үндэслэн төрийг төлөөлөн шинжээчээр ажиллах, маркшейдерын хэмжилт хийх, мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргах үйлчилгээний хураамж;

66.3.8.салбарт мөрдөгдөх дүрэм, стандарт, норм, нормативыг боловсронгуй болгох зорилгоор Барилгын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.7-д заасны дагуу, эсхүл иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын орлого;

66.3.9.хайгуулын ажлын үр дүнгийн тайлан-техник, эдийн засгийн үндэслэл, техникийн зураг төсөлд хийсэн зохиогчийн хяналтын гэрээт ажлын экспертын баталгаажуулалтын үйлчилгээний хураамж;



66.3.10.бусад орлого.

## **АРВАН ТАВДУГААР БҮЛЭГ МЭДЭЭЛЛИЙН САН**

### **68 дугаар зүйл.Мэдээллийн сангийн хэлбэр**

68.1.Геологи, уул уурхайн салбарын мэдээллийн сан /цаашид “мэдээллийн сан” гэх/-г цахим болон цаасан хэлбэрээр бүрдүүлнэ.

68.2.Мэдээллийн сан нь төрийн өмч байна.

### **69 дүгээр зүйл.Геологи, уул уурхайн салбарын мэдээллийн сангийн төрөл**

69.1.Мэдээллийн сан нь дараах үндсэн сангуудаас бүрдэнэ:

69.1.1.үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн сан;

69.1.2.хайгуул, ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн сан;

69.2.Энэ хуулийн 69.1.1-д заасан мэдээллийн санг геологи, судалгааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, 69.1.2-т заасан мэдээллийн санг ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тус тус хариуцна.

69.3.Энэ хуулийн 69.1.1, 69.1.2-т заасан мэдээллийн сан нэгдмэл байх бөгөөд энэ хуулийн 71.1, 71.2-т заасан байгууллагууд мэдээллийг солилцоно.

69.4.Мэдээллийн сангийн үндсэн эх үүсвэрийн дэлгэрэнгүй жагсаалт, мэдээллийн сан бүрдүүлэх, боловсруулах, хөтлөх, ашиглах, хадгалах, хамгаалах журмыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

69.5.Хуульд хаалттай байхаар заасан, эсхүл төрийн нууцад хамаарах мэдээллээс бусад мэдээлэл олон нийтэд ил тод байна.

### **70 дугаар зүйл.Мэдээллийн сангийн бүрдэл**

70.1.Энэ хуулийн 69.1.1-д заасан үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн сан нь дараах бүрдлээс бүрдэнэ:

70.1.1.геологийн зургийн мэдээлэл;

70.1.2.геохимийн мэдээлэл;

70.1.3.геофизикийн мэдээлэл;

70.1.4.гидрогеологийн мэдээлэл;

70.1.5.эрдсийн баялгийн мэдээлэл;

70.1.6.ашигт малтмалын нөөцийн мэдээлэл;

70.1.7.геоэкологийн мэдээлэл;

70.1.8.инженер геологийн мэдээлэл;

70.1.9.палеонтологийн мэдээлэл;

70.1.10.давхарга зүйн мэдээлэл;

- 70.1.11.тектоникийн мэдээлэл;
- 70.1.12.хагарлын мэдээлэл;
- 70.1.13.баримт материалын бүртгэл;
- 70.1.14.геологийн судалгааны ажлуудын бүртгэл;
- 70.1.15.газрын тосны мэдээлэл;
- 70.1.16.бусад.

70.2.Энэ хуулийн 69.1.2-т заасан тусгай зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн сан нь дараах бүрдлээс бүрдэнэ:

70.2.1.ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн бүртгэл;  
70.2.2.өргөдлийн бүртгэл;  
70.2.3.сонгон шалгаруулалтын бүртгэл;  
70.2.4.хориглосон газрын бүртгэл;  
70.2.5.хязгаарласан газрын бүртгэл;  
70.2.6.хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн бүртгэл;

70.2.7.хайгуулын ажлын төлөвлөгөөний мэдээлэл;  
70.2.8.хайгуулын ажлын тайлан мэдээлэл;  
70.2.9.эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцэгдэх хайгуулын ажлын үр дүнгийн тайлан-техник, эдийн засгийн үндэслэлийн бүртгэл;

70.2.10.ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөний мэдээлэл;  
70.2.11.ашиглалтын үйл ажиллагааны тайлангийн мэдээлэл;  
70.2.12.баяжуулах үйлдвэрийн тусгай зөвшөөрлийн бүртгэл;  
70.2.13.баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны төлөвлөгөөний мэдээлэл;

70.2.14.баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны тайлангийн мэдээлэл;  
70.2.15.тусгай зөвшөөрөл эзэмшигчийн улсын төсөвт төлсөн татвар, төлбөр, хураамжийн мэдээлэл;

70.2.16.техникийн зураг төсөл, уурхайн хаалтын төлөвлөгөө, санхүүжилтийн баталгаа, уурхайн хаалтын мэдээлэл;

70.2.17.бусад.

## **71 дүгээр зүйл.Мэдээллийн сан хөтлөх, бүрдүүлэх**

71.1.Энэ хуулийн 69.1-д заасан мэдээллийн санд дараах байгууллага, хуулийн этгээд энэ хуульд заасны дагуу мэдээлэл бүрдүүлэх үүрэгтэй:

71.1.1.геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

71.1.2.геологи, судалгааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага;

71.1.3.ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага;

71.1.4.тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд;

71.1.5.улсын төсвийн хөрөнгөөр судалгааны ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан хуулийн этгээд;

71.1.6.геологи, уул уурхайн шинжлэх ухааны, боловсрол, судалгааны төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд;

71.2.Энэ хуулийн 69.1-д заасан мэдээллийн санд дараах байгууллага, хуулийн этгээд энэ хуульд заасны дагуу мэдээлэл бүрдүүлэхэд оролцох үүрэгтэй:

71.2.1.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

71.2.2.байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

71.2.3.Монголбанк;

71.2.4.гаалийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага;

71.2.5.татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага;

71.2.6.усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага;

71.2.7.газрын харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага;

71.2.8.статистикийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага;

71.2.9.аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга;

71.2.10.цөмийн энергийн комисс;

71.2.11.хууль тогтоомжид заасан бусад.

71.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь анхдагч мэдээлэлд хамаарах нэгтгэсэн биет болон биет бус мэдээллийг геологи, эрдэс баялгийн мэдээллийн санд бүртгүүлэх үүрэгтэй;

71.4.Иргэн, байгууллага, хуулийн этгээд нь шинжлэх ухаан, технологийн сан, олон улсын болон гадаадын зээл, тусламж, төсөл, хөтөлбөрийн хүрээнд бүрдүүлсэн геологи, уул уурхайн мэдээллийг геологи, эрдэс баялгийн мэдээллийн санд үнэ төлбөргүй төвлөрүүлэх үүрэгтэй.

71.5.Энэ хуулийн 71.1.4, 71.1.5, 71.1.6-д заасан аж ахуйн нэгж, байгууллага, хуулийн этгээд нь өөрийн хөрөнгөөр цуглуулж бүрдүүлсэн өгөгдөл, мэдээллийг улсын санд төлбөргүй өгөх үүрэгтэй.

## **АРВАН ЗУРГААДУГААР БҮЛЭГ УУЛ УУРХАЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САНХҮҮ БҮРТГЭЛИЙН ОНЦЛОГ, НӨХӨН ТӨЛБӨР**

### **72 дугаар зүйл.Уул уурхайн үйлдвэрлэлийн санхүү бүртгэлийн онцлог**

72.1.Хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уг зөвшөөрлөөр олгогдсон талбайд хийсэн хайгуулын ажлын зардал болон уурхайг ашиглалтад бэлтгэсэн зардлыг үйлдвэрлэл эхэлснээс хойш 5 жилийн хугацаанд тогтмол хэмжээгээр үйлдвэрлэлийн зардалд оруулж, шимтгэлийн сан байгуулна.

72.2.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрөл эзэмших, шилжүүлэх, талбайг шилжүүлэн авахтай холбогдон гарсан зардлыг тухайн тусгай

зөвшөөрөл хүчинтэй байх хугацаанд жил тутам ижил хэмжээгээр үйлдвэрлэлийн зардалд оруулж, шимтгэлийн сан байгуулна.

72.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч уул уурхайн үйлдвэрлэлд ашиглагдаж байгаа үндсэн хөрөнгөд түүний элэгдэл, хорогдлын шимтгэлийн сан байгуулна.

72.4.Үйлдвэрлэл болон дэд бүтцэд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зарцуулсан эд хөрөнгийн элэгдэл, хорогдлын шимтгэлийн санг тэдгээр барилга, байгууламжийн ашиглагдах хугацаанд тогтмол хэмжээгээр байгуулж, тэдгээртэй холбогдон гарах зардлыг тухайн санхүүгийн жилийн үйлдвэрлэлийн зардалд оруулан тооцно.

72.5.Уул уурхайн үйлдвэрлэл явуулахад зайлшгүй шаардлагаар хийгдсэн бүх төрлийн засварын зардлыг үйлдвэрлэлийн зардалд тооцно.

72.6.Энэ хуулийн 72.1, 72.2, 72.3, 72.4, 72.5-т заасан заалтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон журам, зааврыг санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

### **73 дугаар зүйл.Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн геологи, хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөр**

73.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь улсын төсвийн хөрөнгөөр геологи, хайгуулын ажил гүйцэтгэхэд гаргасан зардлыг ашиглалт явуулж эхэлсэн хугацаанаас эхлэн улсын төсөвт гэрээний үндсэн дээр нөхөн төлнө.

73.2.Энэ хуулийн 60.2.16-д заасан бүх төрлийн зардлыг тооцно.

73.3.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу хувьчлагдсан аж ахуйн нэгжийн хувьд өмнө нь улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн геологи, хайгуулын ажлын зардлын дүнгээс тухайн ордын нэгэнт ашиглагдсан ашигт малтмалын хэмжээнд ногдох геологи, хайгуулын зардлыг хувь тэнцүүлэн хасч, үлдэгдэл нөөцөд ногдох геологи, хайгуулын ажлын зардлыг нөхөн төлнө.

73.4.Жилд төлөх нөхөн төлбөрийн хэмжээг тухайн жилд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээнд тулгуурлан тогтооно.

73.5.Нөхөн төлбөрийг гэрээнд заасан хугацаанд барагдуулаагүй бол хугацаа хэтэрсэн хоног тутамд төлөөгүй төлбөрийн үнийн дүнгийн 0,1 хувиар тооцон алданги ногдуулна.

## **АРВАН ДОЛООДУГААР БҮЛЭГ ХАРИУЦЛАГА, БУСАД**

### **74 дүгээр зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

74.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

74.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

74.3.Энэ хуулиар зохицуулсан харилцаа нь бусад хууль тогтоомжийн хэм хэмжээтэй зөрчилдвөл энэ хуулийн зохицуулалтыг баримтална.

74.4.Энэ хуулийн 23.3.4, 28.3.2-т заасан үндэслэлээр тусгай зөвшөөрлийг цуцалсан тохиолдолд тухайн хуулийн этгээдэд 20 жилийн хугацаанд дахин тусгай зөвшөөрөл олгохгүй.

#### **75 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

75.1.Энэ хуулийг 20.. оны .. дүгээр сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**